

03 дугаар сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, засаг дарга нарын нэгдсэн уулзалт, семинарт аймгийн ИТХ-ын дарга Д.Хосбаяр, Засаг дарга М.Идэрбат нар хамрагдан улмаар Засгийн газрын гишүүд болон аймгийн Засаг дарга нарын хамтын ажиллагааны зорилгыг батламжиллаа.

Аймгийн засаг дарга М.Идэрбат БНЧУ-аас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ийржи Бродский, АНУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд МайкС Клечески, Япон Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Кобаяши Хироюки болон Тика Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлагийн Монгол улс дахь суурин төлөөлөгч Эмрах Устаөмэрт нартай албан уулзалт хийсэн ба уулзалтын үр дүнд дараах асуудлуудыг шийдвэрлэхээр боллоо.

- Япон улсын “Өвсний үндэс –Хүний аюулгүй байдал” хөтөлбөрийн хүрээнд “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 4-р цэцэрлэгийн барилгын засвар” хийх төслийн 690 сая төгрөгний буцалтгүй тусламжийн гэрээнд гарын үсэг зурлаа. Түүнчлэн Япон Улсын бизнес эрхлэгчид, хувийн хэвшилтэй хамтран ажиллах хөрөнгө оруулалтын уулзалт, хурлыг хамтран зохион байгуулахаар харилцан тохиролцлоо.

- АНУ-ын элчин сайдын яамны зүгээс одоогоор Монгол Улсад хэрэгжүүлж буй англи хэлний боловсролыг дэмжих солилцооны хөтөлбөрүүд, соёлын өвийг хамгаалах элчин сайдын нэрэмжит сангийн талаар танилцуулсан ба Сүхбаатар аймгийн хөгжлийн давуу тал,эдийн засаг, аялал жуулчлал,соёл боловсролын талаар харилцан санал солилцлоо. Аймгийн Засаг даргын зүгээс Сүхбаатар аймагт “Америкийн соёл мэдээллийн төв” байгуулах саналаа илэрхийлсэнийг АНУ-ын элчин сайд дэмжиж хамтран ажиллахаар боллоо.

- Чех улсын элчин сайдтай хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, усан хангамжийн салбарт хамтран ажиллах боломжийн талаар онцлон харилцан санал солилцож, сумдын бие даасан дулаан хангамжийн эх үүсвэр, ус цэвэршүүлэх салбарт төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд үндэслэн хамтран ажиллахаар тохиролцлоо.

- ТИКА Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлагт хүн чулуун соёлын өвийг хамгаалах, аймгийн нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх, бэлчээрийн усан хангамжийг сайжруулж цэвэршүүлэх төхөөрөмж нийлүүлэх зэрэг төслүүдэд хөрөнгө оруулах саналыг тавьсан ба ТИКА байгууллагаас уг саналыг бүх талаар дэмжин ажиллаж хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээ илэрхийллээ.

- Мөн аймгийн Засаг дарга Улаанбаатар хотод албан томилолтоор ажиллах үедээ аймгийн ИТХ-ын дарга Д.Хосбаярын хамт үүрэн холбооны оператор Unitel компанийн захиралуудтай уулзалт хийж Эрдэнэцагаан , Баруун-Урт сумын зам дагуу бүрэн сүлжээтэй болгох, гэр хороололд шилэн кабел тавих асуудлаар хамтран ажиллах санал солилцсон ба Баруун-Уртаас Чингис хот хүртэл сүлжээтэй болгох талаар саналыг компанийн зүгээс судалж үзэж хамтран ажиллахаар болов.

Сүхбаатар аймгийн Засаг дарга, Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүртээмжтэй хүргэх, сурталчлах ажлын хүрээнд “Номадик контент” ХХК болон орон нутагт тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн байгууллага болох "BBS" телевиз, "Сүхбаатарын өнгө" сонин, "SB info" сайт, үндэсний мэдээллийн "МОНЦАМЭ" агентлагтай хамтран ажиллах гэрээ байгуулав. Дээрх хэвлэл мэдээллийн байгууллагууд 2021 онд аймгийн хэмжээнд улс болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил, Засаг дарга, Тамгын газраас зохион байгуулж, хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний талаарх мэдээллийг шуурхай бэлтгэн, иргэдэд бодитой мэдээллийг хүргэх чиглэлээр хамтран ажиллана.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 14 дүгээр зарлигийн дагуу төрийн дээд шагнал гардуулах ёслол хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонг 4, Алтан гадас одонг 21, Цэргийн гавьяаны одонг 2, Хөдөлмөрийн хүндэт медалийг 21 иргэнд тус тус УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, аймгийн ИТХ-ын дарга Д.Хосбаяр, аймгийн Засаг дарга М.Идэрбат болон холбогдох албаны хүмүүс гардуулж өглөө.

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд "Ногоон түвшин"-д шилжсэн байсныг үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Засаг даргын А/200 дугаар захирамжаар 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 04 дүгээр сарын 05-ны 06:00 цаг хүртэл Мөнххаан, Баруун-Урт, Түмэнцогт, Наран, Халзан, Уулбаян сумдыг гамшгаас хамгаалах бүх нийтийн зэрэг /улаан түвшин/-т, Онгон, Дарьганга, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Асгат, Баяндэлгэр сумыг гамшгаас хамгаалах бэлэн байдлын /Улбар шар/-т тус тус шилжүүлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр: ХШҮДАХэлтсээс аймгийн 2020 оны ЭЗНХҮзүүлэлтийн тайлан, 2020 оны Ил тод байдлын биелэлтийн тайлан, ХНЧТСАЗорилт, Сайдын гэрээний биелэлтийн тайланг тус тус цахимаар болон цаасан хэлбэрээр ЗГХЭГ-т хүргүүлсэн

“Үр дүнд суурилсан ХШҮ-ний чадавхийг бэржүүлэх нь” сэдэвт сургалтыг 6-сумын төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, бусад төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгууллаа. Мөн ЗГ-аас шинээр батлагдсан журмуудыг хэрэгжүүлэхэд баримтлах арга зам, загвар, биелэлтийг хэрхэн тайлагнах аргачлалыг танилцуулж, Засгийн газраас болон орон нутгаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, явцтай танилцан зөвлөмж, арга зүйгээр ханган бодлогын дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Архигүй Сүхбаатарчуудын төлөө” дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүгнэлтийг ИТХ-ын ажлын албанд хүргүүлээ.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2021 оны 3 дугаар сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 10726,8 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 2025,0 сая төгрөгийн орлого орж нийт 12751,8 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

3 сарын байдлаар Улсын төсөвт 662,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 690,1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 104,2 хувиар, Орон нутгийн төсөвт 2029,1 сая төгрөг

төвлөрүүлэхээс 2255,1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 111,2 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 1469,9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 11553,0 төгрөгийн санхүүжилт олгож байгууллагууд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан болно.

13 төсвийн шууд захирагчийн 2020 оны 4 дугаар улирлын санхүүгийн тайланг, төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг шалгаж хүлээн авч дуусан аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төрийн аудитын газарт аудит хийлгэхээр хүргүүлээд байна.

2020 оны Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлан хүлээн авах хугацаа ковид-19 нөхцөл байдлаас шалтгаалан 2 сарын 26-ны өдрийг хүртэл сунгаж аймгийн хэмжээний нийт 916 ААНБ тайланг хүлээн авахаас 717 ААНБ буюу 79 хувь нь хуулийн хугацаантай тайлагнасан бөгөөд 298 ААНБ-ыг баталгаажуулсан байна.

2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэлийн баримт материалыг Төрийн аудитын газарт аудит хийлгэхээр хүргүүлсэн байна.

Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол гарсантай холбогдуулан төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлж цалин, тэтгэврээс бусад зарлагыг эрэмбэ тогтоон санхүүжүүлэх арга хэмжээг авч ажиллалаа.

Орон нутгийн өмчийн газар: 2021 оны 02 дугаар сард аймгийн Засаг даргын захирамжаар нийт 9 үнэлгээний хороо байгуулагдаж, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг tender.gov.mn сайтаар дамжуулан тендерийг зарлан ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба: Тус алба нь Сангийн сайдын баталсан удирдамжийн хүрээнд Бичигт дэх Гаалийн газарт санхүүгийн хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар нийт 14837.6 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнээс 580.9 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн 2 салбар акт тогтоож, 11 заалттай зөвлөмж үйлдэж ажиллалаа.

Албаны даргын баталсан удирдамжийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газарт санхүүгийн хяналт шалгалт, Тэмүүлэн, Энэрэл өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дотоод аудитын шалгалт хийгдэж байна.

Статистикийн хэлтэс: Албан ёсны статистикийн 3-р сарын 4-ний өдөр явах мэдээнүүдийг анхан шатны нэгжээс цуглуулан авч, хянан шалгаж шивэлтийг бүрэн хийж дамжуулсан. 2020 оны жилийн эцсийн ААНБ-1, ААНБ-2 маягтаар мэдээлэл цуглуултын ажлыг 404 анхан шатны нэгжээс цуглуулан, хянан шалгаж, шивэлтийг хугацаанд нь бүрэн хийж дамжуулсан.

Аймгийн нийгэм эдийн засгийн 2-р сарын танилцуулгыг салбар бүрийн гол гол үзүүлэлтүүдээр нэгтгэн гаргаж тархаасан.

ААНБ-ын үйл ажиллагаанд Корона вирусээс урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөллийн 2 дугаар сарын судалгаанд 76 ААНБ-аас 76 ААНБ-ыг бүрэн хамруулсан.

2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Халзан сумын удирдлагууд, статистик хариуцсан мэргэжилтэн, мэдээ тайланг гаргадаг ажилтнууд болон шинээр томилогдсон 4-н багийн Засаг дарга нарт 1 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд:

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2021 оны 03-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 679 иргэнээс эмэгтэй 316, бүртгэлтэй ажилгүй иргэн 478 иргэнээс, эмэгтэй 214 иргэн байна. 78 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 57 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 33 нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 26 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. Баруун-Урт суманд бий болсон Сүхбаатар аймгийн Тохижилт үйлчилгээ ОНӨҮГазар, Баруун-Урт сумын 1-р цэцэрлэгийн нийт 17 шинэ ажлын байрны мэдээллийг ХЗЗ-н мэдээллийн нэгдсэн санд бүртгэн мэдээлсэн.

Аймгийн төвийн 13 байгууллагын 33 сул ажлын байрыг нээлттэй зарлаж ажилд зуучлах мэдэгдэл хүргүүлэх ажлыг гүйцэтгэж байна .

Төсөл хөтөлбөрийн чиглэлээр:

- Ажлаас чөлөөлөгдсөн 10 иргэдийн тушаалыг үндэслэн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд ажил хайгчаар бүртгэж тодорхойлолт гаргасан.
- 2017-2019 онд санхүүгийн дэмжлэг авсан буюу хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдтэй утсаар холбогдож, мессэж болон биечлэн мэдэгдлийн хуудсыг 12 иргэнд өгч нийт 15 хүний 25284480 сая төгрөг төвлөрүүлэхээс 2 хүний 3110000/ гурван сая нэг зуун арван мянган төгрөгийн төвлөрүүлсэн.
- Аймгийн төвийн 42 байгууллагад 25 ба түүнээс дээш ажилтантай ААНБ-уудад судалгаа ирүүлэх тухай 2021.03.16-ны 1/97 тоот албан бичгийн биечлэн хүргүүлснээр 14 байгууллага ХБИргэний судалгааг ирүүлсэн.
- Мөн 42 байгууллагаас шинээр ажилд орсон болон сул чөлөөтэй ажлын байрны мэдээллийг авч нэгтгэхэд 16 байгууллага 52 иргэнийг ажилд авсан, 9 байгууллагын 44 ажлын байрны захиалга авч ажилд зуучлах нээлттэй зарлан ажлыг зохион байгуулсан.
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 3 сарын 26-нд зохион байгуулах зүү ороох, эсгүүр гаргах оёдлын сургалтанд хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд ажил хайгчаар бүртгэлтэй ажилгүй болон оёдлын сургалтанд хамрагдах хүсэлтэй 11 иргэдийг хамруулахаар нэрсийн жагсаалтыг хүргүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дансанд 88 хүний 27,681.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн авлагыг программд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн малжуулах хөтөлбөрийн 4 иргэний 6,473.2 мянган төгрөгийн найдваргүй авлага, гэрээний хугацаа дууссан болон шүүхийн байгууллагад шилжүүлсэн 45 иргэний судалгааг гарган ХХҮЕГ-т хүргүүлсэн.

Сангийн гүйцэтгэлийн мэдээг, хөрөнгө мөнгө зарцуулах тушаал, шийдвэрүүдийг тухай бүр хэлтсийн мэдээллийн самбар, байгууллагын цахим хуудас, шилэн дансны

нэгдсэн сайтад байршуулан иргэд олон нийтэд мэдээллийг ойлгомжтой, түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлсэн.

Аудитын зөвлөмжийн биелэлтийг хангах төлөвлөгөөт ажлын хүрээнд 147 иргэнд хугацаатай мэдэгдэх хуудас өгч 31 иргэн 17,821.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111-н хэрэгжилтийг хангах ажлаар Сумын ХЭХАХ мэргэжилтэн нарт Засгийн газрын тогтоол, судалгааны маягтыг албан тоотоор хүргүүлж, аргазүйн зөвлөгөө өгч аймгийн хэмжээнд 25 ба түүнээс дээш ажилтантай 33 байгууллагаас судалгааг авч нэгтгээд байна.

Нийгмийн халамжийн талаар: 2021 оны 03-р сард 13 сумын 350 иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, ахмадын хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийг хүлээн авч нийгмийн халамжийн Wais программд баталгаажуулсан.

Баруун-Урт сумын нийгмийн халамжийн тэтгэвэрийн 388 иргэний дансны мэдээллийг ehalamj программд оруулж иргэний мэдээллийг шинэчилсэн.

- 312 иргэний 93,830,180 мянган төгрөгийн тэтгэвэр ,
- 1666 иргэний 175,413,050 мянган төгрөгийн тэтгэмж ,
- 40 иргэний 4,955,000 мянган төгрөгийн ахмадын хөнгөлөлт,
- 226 иргэний 8,072,270 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийг хаан банк, төрийн банкаар илгээсэн.

Нийгмийн халамжийн мэдээллийн системээр олгогдох

- 629 иргэний 23,123,104 мянган төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж,
- 3306 иргэний 157,679,617 мянган төгрөгийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн,
- 2 иргэний 4000,0 сая төгрөгийн ихэр хүүхдийн тэтгэмжийн,
- 132 иргэний 51,048,666 мянган төгрөгийн өрх толгойлсон эхийн тэтгэмж гарган тулган баталгаажуулж олгоод байна.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан өрхүүдэд хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх хүнсний дэлгүүр сонгон шалгаруулах тендерийг хүчингүй болгож НӨАТ-н баримт олгодог хүнсний дэлгүүр, зах, бөөний төвөөр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх ХХҮЕГ-ын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/581 тоот чиглэл ирсэн. Үүний дагуу ХХҮГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 1/83 тоот хүсэлтийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн. Орон нутгийн өмчийн газар тендерт оролцсон аж ахуй нэгжүүдэд тендер цуцлагдсан мэдэгдлийг хүргүүлсэн.

03 дугаар сард олгох 1209 өрхийн 5568 иргэний 67816.0 мян төгрөгний жагсаалтыг программаас татаж тулган халамжийн сангийн мэргэжилтэнд өгч санхүүжилтийг шилжүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2021 оны 03 дугаар сарын 09-ний “Бүлгийн төсөл хэрэгжүүлэх” удирдамжийн дагуу 13 сумдын мэргэжилтнүүдэд чиглэл хүргүүлж ажилласан. Мөн бүлгийн төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчилэн газрын даргаар батлуулан гарган ажиллаж байна. Баруун-Урт суманд бүлгийн төслийг 03 дугаар сарын 11-ний өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хүлээн авах зарыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сайт болон сумдуудын группт постлон иргэдэд мэдээллээр ханган ажиллаж 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 3 бүлгийн 3 төсөл бусад материалын хамт хүлээн аваад байна.

Баруун-Урт суманд 2021 онд хөгжүүлэх 50 өрх, дэмжлэг туслалцаа шаардлагатай 22 өрх сонгон ажиллахаар болж өрхийн гишүүдэд дараах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөгөө гаргаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

- ✚ Аж ахуйн эрхлэлтийн сургалтанд-18 өрхийн 29 иргэн
- ✚ Мэргэжил олгох сургалтанд-29 өрхийн 37 иргэн
- ✚ Санхүүгийн дэмжлэгт хамрагдах-17 өрхийн 22 иргэн
- ✚ Ганцаарчилсан зөвлөгөө -50 өрхийн 54 иргэн
- ✚ Нийтийн хамарсан ажилд хамрагдах-31 өрхийн 45 иргэн
- ✚ Бүлгийн ногоонд хамрагдах-17 өрхийн 24 иргэн
- ✚ Гэрээт малчин-3 өрхийн 3 иргэн
- ✚ Ажилд зуучлах-17 өрхийн 18 иргэн

Халамжийн үйлчилгээний чиглэлээр:

- ✚ Өдрийн үйлчилгээ-4 өрхийн 4 иргэн
- ✚ Сэргээн засах үйлчилгээ-6 өрхийн 6 иргэн
- ✚ ОНО төсөлд хамрагдах- 7 өрхийн 7 иргэн
- ✚ Орон байрны асуудлыг шийдвэрлүүлэх-2 өрхийн 2 иргэн

Ахмадын амралтанд 3 сард нийт 43 ахмад амарч сувилуулсан. Тус сард их цэвэрлэгээ хийлгэж, бүх өрөөний шкабны нугас, боолтыг чангалах, өрөөнүүдийн хөшиг тогтоогчийг засах, усан санг цэвэрлэх, 2 байрны үүдний кордиорыг будаж, амрагчдын байрлаж байгаа байрны 00-ийг шинэчилж шинээр 3 султуур байрлуулсанаар урьд нь бохир нь бөглөрч байсан асуудлыг арилгаж өрөөнүүдийн тохижилтын ажлыг хийж чийрэгжүүлэлтийн өрөө болон сэргээн засах өрөөнд их цэвэрлэгээ, аритгал халдваргүйжүүлэлтийг хийж ажиллалаа.

Ахмадын амралт сувиллын ээлж эхлэхэд ажилтан албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгаа өгч гарын үсэг зуруулан ажиллалаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссыг хуралдуулж хугацаа дууссан 4 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгаж ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан “Сүхбаатар ариутгал” байгууллагад тусгай зөвшөөрлийг шинээр олголоо.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр АНЭ-т нүдний микроскопи, мобайль технологи худалдан авах техникийн тодорхойлолтыг гарган батлуулж тендер зарлахад бэлэн болгож ОНӨГ-т хүргүүлээ.

Корона вирусын түргэвчилсэн оношлуур худалдан авах зардалд Гамшгийн эрсдлийн сангаас 36,2 сая төгрөгийг шийдвэрлүүлэн 2550ш оношлуур худалдан авлаа.

Аймгийн ахмадын хороотой хамтран “Ахмад настанд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх нь” сургалтыг зохион байгуулж 2020-2024 онд ахмад настны эрүүл мэндийн талаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар танилцуулга, мэдээлэл хийлээ. Мөн Геронтологийн үндэсний төвөөс зохион байгуулсан “Ахмад настанд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд” цахим сургалтанд АНЭ, Өрх, сумдын ахмадын асуудал хариуцсан 18 эмч, мэргэжилтнийг хамруулав.

ЭМЯ-ны ТЗУГ-т Ковид-19 Коронавируст халдварын Улаанбаатар хот дахь нөхцөл байдалтай холбогдуулан дайчлан ажиллуулах эмч, эмнэлгийн ажилтны судалгааг гаргаж хүргүүлэв.

Эрүүл мэндийн төвийн дарга, сумдын Засаг дарга нарыг оролцуулан “Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тулгамдаж буй асуудал” хэлэлцүүлэг зохиог байгуулав.

Эрдэнэцагаан сумын Бичигт боомтод МХГ, ОБГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн Мөнх туурайн тамга ХХК-ний үйл ажиллагаатай танилцан шинэ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллах талаар газар дээр нь заавар зөвлөмж өгсөн.

АНЭ-ийн Шуурхай хариу арга хэмжээний багийн гишүүдэд Коронавируст халдварын оношилгоо, эмчилгээний удирдамж сэдвээр сургалт явуулж нийт 18 мэргэжилтэн, ажилтныг хамруулав.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн БЗДХ-ын кабинетэд, Сүрьеэгийн тасагт дэмжлэгт хяналт хийн цаашид анхаарах асуудлууд болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн “Сүрьеэгийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх” цахим хэлэлцүүлэгийг 36 эмч эмнэлгийн ажилтанг цахимаар зохион байгуулсан.

Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийг "Цаг явсаар байна" уриан дор тэмдэглэн өнгөрүүлж ХӨСҮТ, НЭМҮТ- ээс зохион байгуулж буй цахим сургалтанд ЭМГ, АНЭ, Анхан шатны эрүүл мэндийн төвүүд, Ерөнхий боловсролын сургуулийн 54 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан “Ундны усны зохистой хэрэглээ, ус хадгалах саванд тавигдах эрүүл ахуй, хуванцар савны хэрэглээ ба эрүүл мэнд сэдвүүдээр Ус түгээх цэг, эрүүл мэндийн байгууллага, худалдааны төвүүдээр үйлчлүүлж буй иргэдэд гарын авлага, брошур тарааж мэдээлэл хүргэсэн.“Сүхбаатарын өнгө” сонинд “Ундны усны эрүүл ахуй буюу гэрийн нөхцөлд ус цэвэршүүлэх энгийн аргууд”, “Сүрьеэ өвчний шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх, илрүүлэх”, “ Хачигт халдвараас сэргийлье” мэдээлэл бэлтгэн хэвлүүлсэн.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах аймгийн хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулж зорилтот бүлгийн болон тархвар судлалын заалтаар хийсэн 11060 хүн тун томуугийн вакцины зарцуулалтын мэдээ, зарцуулсан зүү тариурын тооцоог нэгтгэж, ХӨСҮТ-д хүргүүлсэн.

Коронавирусын эсрэг вакцинд хамруулахад шаардлагатай эмч, эрүүл мэндийн ажилтны хамгаалах хувцас хэрэгсэл /халад-3000ш, нүүрний хаалт-1510ш, нэг удаагийн маск-17360ш, малгай-8680ш/ хүлээн авч, АНЭ, өрх, сумдын эрүүл мэндийн төвийн байнгын болон явуулын цэгт хуваарилалт хийсэн.

Дөрөв. Хууль, эрх зүйн чиглэлээр:

Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий аймгийн зөвлөлийг байгуулахаар төлөвлөж, агентлаг, албадаас холбогдох чиглэлээр судалгаа авч ажилласан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2021 оны төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, батлууллаа. Төлөвлөгөөг нийт агентлаг, алба, сумдын ЗДТГ-т хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг үүрэг болгосон.

Аймгийн Засаг даргын захирамжаар Улсын бүртгэлийн хэлтсийн ажлын байрны засварын ажилд 8,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр болсон.

Архивын чиглэлээр: Лавлагаа 106, хуулбар 52 нийт 158 иргэдэд хөдөлмөрчдөд давхардсан тоогоор 7900 гаруй хадгаламжийн нэгжээр үйлчилсэн.

Цахимд хадгаламжийн нэгж буюу 1326 хуудас баримтыг скайнер, photoshop-д оруулаад 373 заалт баримтыг програмд оруулсан байна.

Нөхөн бүрдүүлэлтээр Барилгын зураг төслийн 25 хадгаламжийн нэгж хүлээн авсан.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ: авсан мэдүүлгийн тоо-185, анхны бүртгэл-25, өмчлөх эрх шилжих гэрээ-20, барьцааны гэрээ-114, бүртгэлд өөрчлөлт оруулах -3, лавлагаа хуулбар-22, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-48,

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ: Хүлээн авсан мэдүүлгийн тоо-124, өмчлөх эрх шилжих гэрээ-16, барьцааны гэрээ-67, бүртгэлд өөрчлөлт оруулах -8, лавлагаа хуулбар-5 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-49, нийт бичигдсэн лавлагааны тоо-3

Хуулийн этгээдийн бүртгэл: 2020 оны 03 дугаар сарын байдлаар улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн тоо 1182. Тухайн сард шинээр нийт ХХК-4, төрийн бус байгууллага-2, татан буугдсан бүртгэл 1, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-4, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-6, хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт хийсэн-10, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон-10, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг-1, лавлагаа-0

Иргэний бүртгэл: Иргэний бүртгэлийн тасаг нь 2020 оны 04 сарын байдлаар нийт 148 төрөлт, гэрлэлт 38, гэрлэлт цуцлалт 4, үрчлэлт 5, эцэг тогтоолт 5, овог нэр өөрчлөлт 12, нас баралт 51, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 0, үндэсний энгийн гадаад паспорт 23, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 77, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 534 тус тус бүртгэгдэж олгосон байна.

Шүүхийн шинжилгээний алба: Албаны бие бүрэлдэхүүн Цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнд орж ажиллан жижүүрт 30 удаа гарч ажилласнаас хүний амь нас хохирсон хэргийн дуудлаганд 3 удаа, хулгайн хэргийн дуудлаганд 14 удаа, зам тээврийн ослын дуудлаганд 5, бусад хэргийн дуудлаганд 12 удаа, нийт 34 удаа хэргийн газрын үзлэгт оролцон хэргийн газрын үзлэгээр гутлын мөр 13 ширхэг, гарын мөр 19 ширхэг, тээврийн хэрэгслийн мөр 11 ширхэг, бичил мөр 0 ширхэг, биологийн гаралтай мөр 0 ширхэг, эвдлэгч багажийн мөр 1 ширхэг бусад ул мөр 9 ширхэг, ул мөр илрээгүй үзлэгийн тоо 19 ширхэг нийт 37 ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авлаа.

Тус албаны шинжээч эмч нар нь 04 дугаар сарын байдлаар хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 64 удаа хийснээс хүнд-1, хүндэвтэр-1, хөнгөн-23, гэмтлийн зэрэгт хамаарахгүй-21, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй-18 дүгнэлт гаргасан байна. Бэлгийн холбогдолтой-2 шинжилгээ хийсэн байна.

Гэмт хэргийн болон бусад шалтгаанаар нас барсан 4 хүнд шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийж дүгнэлт гаргалаа. Мөн задлан шинжилгээний явцад цогцосноос эд эрхтэний дээж материал болон цусан дахь этилийн спиртын хувь хэмжээг тодорхойлох зорилгоор заавар журмын дагуу дээж материалыг авч, лабораторит химийн 24 шинжилгээ хийж дүгнэлт гаргалаа.

Живой скайнер ажлын станцаар нийт 91 хүний гарын дардасыг авч Адис-Папилон ажлын станцын санг баяжуулан ажиллаа.

Нийт 986 кадр гэрэл зураг авагдсан байх ба шинжилгээний 82, хэргийн газрын

үзлэгийн 632, цогцосны гадна үзлэг болон задлан шинжилгээний 57, бусад ажиллагааны 215 кадр гэрэл зураг авагдсан.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд:

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр: Сумын хөгжлийн индекс тооцох мэдээллийг эхний улиралд багтаан цахим системд оруулах тогтоолын дагуу 2020 оны жилийн эцсийн байдлаарх 13 сумын хөгжлийн нийт 42 тоон мэдээллийг цахим системд оруулж хянан баталгаажуулж илгээлээ.

Монгол улсын 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Сүхбаатар аймагт хэрэгжүүлэх нийт 56 төсөл арга хэмжээний санал, тэдгээрийн хэрэгцээ шаардлагын талаарх дэлгэрэнгүй тайлбарыг хүргүүллээ.

ЗГ-ын 2020 оны 216-р тогтоолын дагуу нутаг дэвсгэрийн Стратегийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын А/109 дүгээр захирамжаар байгуулагдаж батлагдсан аргачлалын дагуу боловсруулах ажлыг эхлүүлээд байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн талаар: Сумдын албан хаагчдад зориулсан “Хөрөнгө оруулалтын үр ашиг” сэдэвт сургалт семинар зохион байгуулах ажлын хэсэг аймгийн ХОХБТХ-ийн даргаар ахлуулан байгуулагдаж сумдыг 4, 4өөр нь бүсчлэн Сүхбаатар, Онгон, Мөнххаан суманд зохион байгуулж нийт 100 орчим албан хаагчийг хамрууллаа. Энэ сургалтаар хөрөнгө оруулалтыг төлөвлөх, худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийг хангах, өмчийн бүртгэлд авах талаарх мэдээлэл анхаарах асуудлуудыг практик жишээнд үндэслэн мэдээлэл зөвлөмж өгч ажиллалаа.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг явуулах, зураг төсөв боловсруулах ажлууд төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.

Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын салбарт: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Хот байгуулалт, дэд бүтцийн хороо мэргэжлийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Хот байгуулалт, дэд бүтцийн хорооноос Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Дөрвөлж ОНӨҮГ, ДБЭХС ТӨХК-ний Сүхбаатар аймаг дахь салбар, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний Сүхбаатар аймгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар зэрэг мэргэжлийн байгууллагуудын ажлын харилцаа холбоог уялдуулах талаарх мэдээллийг сонсч хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд сумдын ИТХ-аас баталсан газар зохион байгуулалт, төлөвлөлтийн цахим системд баталгаажуулсан 2021 оны тухайн жилийн төлөвлөгөөг egazag.gov.mn Сайт, байгууллагын page хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд нээлттэй сурталчлах, тухайн жилийн төлөвлөгөөнд санал авах ажлыг цахимаар зохион байгуулахаар нээлттэй сурталчлан ажиллалаа.

Баруун-Урт сумын засаг даргын захирамжаар 27 нэгж талбарт газар эзэмших эрхийн дуудлага худалдаа зохион байгуулагдаж газрын төлбөрийн орлого бүрдүүлэлтэнд 26.708.800 төгрөг төвлөрүүлээд байна. Баруун-Урт суманд хүчингүй

болсон 24 байршил газрыг дахин зарлаж явуулахаар төлөвлөөд байна. Энэ сард нийт Баруун-Урт, Сүхбаатар сумдад 6-н байршлын дуудлага худалдаа амжилттай зохион байгуулагдаж орон нутгийн төсөвт 28636,3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Газрын кадастрын системд бүртгэлтэй байгаа өмчлөлийн газруудын татварын ногдуулалт бүрэн үүссэн.

Газрын кадастрын вэб системээр дамжуулан иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн 55 хүсэлтийг судалж шийдвэрлэн ажилласан байна. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар 20 иргэн хуулийн этгээдийн хүсэлтийг шийдвэрлэсэн.

Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах үүднээс газар эзэмших эрх шилжүүлэх болон эзэмих, ашиглах, өмчлөх эрх үүссэн газруудад 5 жил тутам захиалгат хянан баталгаа хийлгүүлэх шаардлагыг тавин 5 нэгж талбарт захиалгат хянан баталгаа хийлгүүлэх “Мэдэгдэх хуудас” өгч ажиллалаа.

Баруун-Урт сумын 22 байршилд хяналтын хэмжилтийг гүйцэтгэж хэмжилт зураглал гарган ажиллаж холбогдох байгууллагуудад хэмжилтийн зурагаар үйлчлэн (44/63 албан бичгийн дагууажиллалаа.

Аймгийн засаг даргын А/139-р захирамжаар томилогдсон ажлын хэсэг Уулбаян сумын 75 ортой дотуур байрны барилга угсралтын ажилд улсын комиссын бүрэлдэхүүнийг зохион байгуулж 2021 оны 03 сарын 25-ны өдөр байнгын ашиглалтад хүлээн авлаа.

Баруун-Урт сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажлын хэсгийн хурлаар ажлын төсөв болон сүүлд батлагдсан төсөв хоёрыг тулган саналыг хүлээн авсан байна.

2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 9 төсөл арга хэмжээний ажлын зураг төсвийн даалгавар боловсруулан холбогдох газруудад хүргүүлээд байна.

2021 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих зайлшгүй шаардлагатай Наран, Онгон, Дарьганга сумдад хэрэгжиж буй барилга, угсралт, их засварын ажлуудтай ГХБХБГ-ын мэргэжилтнүүд танилцан заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Хот байгуулалт кадастрын мэдээллийн санд 10 хуучин барилга байгууламж нэмж оруулсан байна.

Хөдөө аж ахуйн салбарт: 2020-2021 онд аймгийн хэмжээгээр 13 сумын 67 багийн 8220 малчин өрхийн 3893,6 мянган толгой мал өвөлжиж, хаваржиж байна.

Аймгийн хэмжээнд нийт 1700,0 мянган мал төллөхөөс 03 сарын 25-ны өдрийн байдлаар төллөвөл зохих хээлтэгчийн 5,5 хувь буюу 93484 толгой мал төллөөд байна. Үүнд:

Эх мал: ингэ - 94, гүү - 1580, үнээ - 2325, хонь - 59893, ямаа – 29592

Төл мал: ботго -94, унага -1580, тугал -2325, хурга -59976, ишиг- 30524

Төл малын хорогдол: ботго -2, унага -38, тугал -66, хурга -563, ишиг -519

2020 оны мал тооллогоос хойш том малын зүй бусын хорогдол тэмээ -8, адуу -710, үхэр -1783, хонь -8652, ямаа -10533 нийт 21686 толгой мал хорогдсон байна.

Бойжиж буй төл: ботго 92, унага 1542, тугал 2259, хурга 59413, ишиг 30005

2021 онд 384 тн ноолуур бэлтгэх урьдчилсан тооцоо гараад байна.

Аймгийн хэмжээнд тэмээ 6, адуу 562, үхэр 1125, хонь 6404, ямаа 7957 нийт 16054 толгой мал хорогдсон байна.

Аймгийн аюулгүй нөөцөд байсан 8000 боодол өвсийг сумдад захиалгын дагуу хувиарлан хөнгөлөлттэй үнээр олгосон.

Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжүүлтээр хэрэгжүүлж байгаа "Ногоон алт-Малын эрүүл мэнд" төсөл, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоотой хамтран аймгийн байгаль, цаг уурын янз бүрийн бүс нутагт үржүүлж буй үүлдэр, омгийн ямааны ноолуурын чанарын үзүүлэлтүүдийн (голч, атираа, урт) өөрчлөлтийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулан судлах, цаашид ямаан сүргийн үржлийн ажлын стратеги төлөвлөгөө боловсруулахад шалгуур үзүүлэлт болгох зорилгоор аймгийн ХХААГ-ын Мал үржлийн албаны мэргэжилтэнүүд, Баяндэлгэр, Онгон сумын ХАА-н тасгийн мэргэжилтнүүдийн хамт "Баяндэлгэрийн улаан" үүлдрийн ямааны 120 ухна, 120 эм ямаанаас ноолуурын дээж авч ажиллаа.

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг хоногоор тооцон сум тус бүрээр гаргаж, 7 хоног бүрийн 1, 4 дэх өдрүүдэд ХХААХҮЯ, аймгийн Онцгой комиссын шуурхай штабт хүргүүлэн ажиллаж байна.

Турк улсын ТИКА төслийн санхүүжилтээр Асгат, Түмэнцогт, Наран сумдын малын бэлчээрт гүн өрмийн худаг гаргуулах мэдээллийг бэлтгэн төслийн газарт хүргүүлээд байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөр 416,500,000 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллана. Үүнд:

Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих Онгон, Наран, Мөнххаан сумдад

Борлуулалтын цэг шинээр барина Бариуун-Урт суманд

Бод малын ангилалтын зогсоол бүх сумдад зэрэг ажлууд хийгдэх юм.

Борлуулалтын цэг шинээр барих барилгын зураг төсөв боловсруулах даалгавар, Бод малын ангилалтын зогсоолын техникийн тодорхойлолтыг тус тус боловсруулж батлуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар Орон нутгийн өмчийн газарт хүргүүлээд байна.

Мал эмнэлгийн газар: Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалын дагуу Мал эмнэлгийн газрын бүтэц орон тоог шинэчлэсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгавар, Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны А/06 тоот тушаал, ажлын удирдамжийг сумдад хүргүүлэн, отор нүүдэл, мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж зориулалтын устгалын цэгт хийж халдваргүйтгэлийн арга хэмжээ

зохион байгуулан ажиллаж байна. 3 дугаар сарын 25-ны байдлаар мал амьтны сэг зэмийн устгалд: адуу-90, үхэр-354, хонь-696, ямаа-1074, бусад амьтны-64 нийт 2278 ширхэг сэг зэмийг цуглуулан хогийн нэгдсэн цэгт төвлөрлүүлэн хаяж халдваргүйтгэлийг хийгээд байна.

Зүй бусаар хорогдсон: тэмээ-8, адуу-710, үхэр-1783, хонь-8652, ямаа-10533 нийт-21686 толгой мал.

Аймгийн 10 суманд: нийтийн эзэмшлийн талбай-61.8м², хашаа хороо-95.0м², өтөг бууц-65.9м², худаг уст цэг-17.4м², бэлчээрийн талбай-62.7м², агуулах зоорь түүхий эд-15.8м², устгалын цэгийн талбай-23,1м², устгалын цэгийн тоо-20 нийт 341.9м² талбайд халдваргүйтгэлийг хийгээд байна.

03 дугаар сард 7 удаагийн дуудлаганд очиж эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч малчид мал бүхий иргэдэд зөвлөмж чиглэл авч ажиллав.

Аймгийн Засаг даргын 02 албан даалгаврын хүрээнд хүүр сэг зэм ариутгал халдваргүйжүүлэлт ажил зохион байгуулахаар 13 сум ариутгалын бодис, халдвар хамгааллын хувцас автомакс бусад дагалдах хэрэгсэл тараан хүргүүлээд байна.

Орон нутагт малын шимэгчтэх өвчинтэй тэмцэх 2021 оны төлөвлөгөөг сумдын Засаг дарга нараар баталгаажуулан авч нэгтгэн аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж газрын даргаар баталгаажуулан МЭЕГ-т хүргүүлсэн.

2021 оны 03 сарын 03-ны өдөр MNS17025:2018 стандартын дагуу мал эмнэлгийн лабораторийн итгэмжлэлд цахим хэлбэрээр орж итгэмжлэлдээ тэнцээгүй учир нян судлал, ариун цэвэр, ийлдэс судлал, шимэгч судлал, молекул биологийн тасгуудад үнэлгээ хийж илэрсэн үл тохиролыг залруулах 3 сарын хугацаатай үүрэг чиглэл өгөв.

Нян судлалын лабораторид 2, Ариун цэврийн шинжилгээнд мах сүүний нийт 20, ийлдэс судлалын лабораторид 3, шимэгч судлалын лабораторид 4 дээж нийт 29-н шинжилгээг хийж гүйцэтгээд байна.

Аймгийн хэмжээнд мал, амьтан, түүхий эд бүтээгдэхүүн, малын тэжээлийн үзлэг шинжилгээний нэгдсэн мэдээгээр аймгийн хэмжээнд сүү, ааруул, цувдай, ноос ноолуур, сүүл өөх, 68755 дээжинд мэдрэхүйн үзлэг шинжилгээ хийгдээд байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, соёл, урлагийн харьяа 16 газарт Мал эмнэлгийн газрын 1/39 тоот зөвлөмжийг хүргүүлээд байна. Мөн 2,4,5,8,9 цэцэрлэгүүдийн мах, сүүний дээжинд рН, үзэж махны шинэлэг байдал тодорхойлж, сүүнд тослог, хуурай бодис, нягт, уураг, хольц, бруцеллёзийн шинжилгээ хийж хариуг тухай бүр нь хүргүүлэн төрөлжсөн мал эмнэлгийн нэгжийн эмчээр мал эмнэлгийн магадлан шинжилгээний QR бүхий гар утасны аппликейшнээр уншиж болох гэрчилгээг олгож байна.

Аймгийн Засаг даргын Хөрөнгө гаргах тухай А/129 дугаар захирамжаар Мал амьтад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархалаажуулалтын ажилд улсын төсвийн санхүүжилтээр 763,85 толгой малын 315016.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 582,92 толгой малын 461558.4 сая төгрөг, иргэн хуулийн этгээдээс 154,2 толгой малын 22051,5 сая төгрөгөөр тус тус санхүүжих нийт 461558.4 сая төгрөг зарцуулагдахаар батлагдсан.

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны чиглэлээр: Хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 19-ний 272 дугаар тогтоолоор баталсан “Норматив тогтоох тухай” тушаалд 1000 хүн ам тутамд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог 4 байхаар тогтоосон. Тус тушаалыг хэрэгжүүлж ажиллах зорилгоор аймгийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуй нэгжийн тоон мэдээллийг сум тус бүрээр гарган Нормативыг цаашид хэрэгжүүлж ажиллах талаар Засаг даргын зөвлөлд танилцуулж, чиглэл авч ажилласан.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл шинээр авах 5 аж ахуй нэгж, сунгах 10 аж ахуй нэгжийн хүсэлтийг хүлээн авч аймгийн засаг даргын А/133, А/136, А/187 дугаар захирамжаар баталгаажуулан олголоо.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаан дээр суурилан ажлын байр нэмэгдүүлсэн, тогтмол үйл ажиллагаа эрхлэх 2-3 үйлдвэрийг ашиглалтад оруулах зорилгоор ИТХ-ын Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний хороо, ХОХБТХ, ХХААГ, “Сүхбатаар хөгжил ҮТП”, ХАҮТ зэрэг төр болон төрийн бус байгууллагын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж үйлдвэрлэлийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийн төсөл боловсруулж ажилласан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Зүүн бүсийн эдийн өсөлтийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Төр, хувийн хэвшлийн Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2021 оны 03 дугаар сарын 05 –ны өдрийн хуралдааны 10 дугаар тогтоолоор шинэчлэн батлуллаа.

ХАҮТ, Мерит төсөлтэй хамтран Орон нутгийн үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих, уул уурхайн компаниудад бэлтгэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор уул, уурхайн компаниудаас бүтээгдэхүүн нийлүүлэлтийн талаар судалгаа авч, судалгааны үндсэн дээр орон нутгийн үйлдвэр эрхлэгчидтэй уулзалт зохион байгууллаа. Мөн энэ ажлын хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газар, Дорнод, Дундговь, Төв аймгийн ЗДТГ, ХХААГ-ын удирдлага, мэргэжилтгүүдтэй онлайн уулзалт зохион байгуулж, аймгууд харилцан туршлага, мэдээллийг солилцлоо.

АНУ-ын ОУ-ын “Хөгжлийн шийдэл” ТББ-ын “Дорнод Best” хөтөлбөртэй хамтран Баруун-Урт сумын бизнес эрхлэгчдэд бизнес төсөл боловсруулах, ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг энэ сарын 10, 11 ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтыг 4 ээлжээр зохион байгуулж, 80 бизнес эрхлэгчийг хамруулсан бөгөөд бизнес төсөл боловсруулах, компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх, түүний үр өгөөж, ач холбогдолын талаарх ойлголтыг өгч, ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлийн журмын талаарх мэдээллийг хүргэсэн.

ХОХБТХэлтсийн дарга, Монголбанк, арилжааны банкнуудын удирдлагууд, ХАҮТ-ын тэргүүн нар телевизийн нэвтрүүлэгт орж, МУ-ын Засгийн Газраас баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөг сурталчлах зорилгоор ажлын байр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих 2 их наядын хөнгөлөлттэй зээлийн нөхцөл, шаардлага, эрэлт хэрэгцээ, аймгийн хэмжээнд хэрхэн хэрэгжиж байгаа талаарх мэдээллийг иргэдэд хүргэж ажиллалаа.

Зам тээвэр, уул уурхайн чиглэлээр: Аймгийн ИТХТ-ийн 2021 оны 09 дүгээр тогтоолоор уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай байгуулах

хамтын ажиллагааны гэрээний ерөнхий нөхцөл боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан, мөн аймгийн Засаг даргын 2021 оны А/149 дүгээр захирамжаар байгуулагдсан уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хэлцэл хийх ажлын хэсгийн хуралдаанаар гэрээ байгуулах аж ахуй нэгжийн мэдээлэл, судалгааг гарган ажиллаж байна.

Аймгийн ИТХТ-ийн 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Сүхбаатар сумын 5-р багийн нутаг “Дөрвөлжин худаг” нэртэй талбайд Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдлийг шийдвэрлэсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/181 дугаар захирамжаар ОУИТБС-ын хэрэгжүүлэх аймгийн дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулсан.

“Эм Эл Цахиурт Овоо ХХК” Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийг уурхайгаас Дорноговь аймаг руу “Цайрт минерал” ХХК-ийн батлагдсан тээвэрлэлтийн чиглэлийн дагуу гүйцэтгэх санал ирүүлсэнтэй холбогдуулан 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Аймгийн засаг даргын орлогчийн баталсан удирдамж, үүрэг чиглэлийн дагуу холбогдох мэргэжлийн байгууллагууд, аж ахуй нэгжүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Цайрт минерал ХХК-ийн батлагдсан Баруун-Урт-Сайншанд чиглэлийн баяжмал тээвэрлэлтийн авто замаар Сүхбаатар, Дорноговь аймгуудын нутгийн зааг Баяндэлгэр сумын Цагаан сүүжийн худаг нэртэй газар хүртэл 172 км явж замын нөхцөл байдалтай танилцаж тус чиглэлийн замын эвдэрсэн хэсгүүд болон олон салаа зам үүссэн хэсгүүдийг гэрэл зураг, координатаар баримтжуулж, ашиглалт, тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуй нэгжүүдийн удирдлагуудад үүрэг, чиглэл өглөө.

Зам тээврийн салбарт: 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр баригдах аймгийн төвийн 5 дугаар тойргийн 5,65км, Баруун-Урт сумын 1-р багт баригдах 3,03км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт зураг, төсөв, техникийн тодорхойлолтыг хүргүүлсэн.

Аймгийн төвийн 2-р тойргийн хатуу хучилттай авто замын засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсөл, төсөвт өртөг боловсруулах гүйцэтгэгч компани “Классик роуд” ХХК-тай гэрээ байгуулж, зөвлөх үйлчилгээний ажлыг эхлүүлсэн.

2021 онд хэрэгжүүлэх авто зам, замын байгууламжийн ажлын зургийн даалгавар, техникийн тодорхойлолтуудыг боловсруулж батлуулан ажиллаж байна.

2021 оны 03 сарын 26-ны өдрийн байдлаар аймгийн Автотээврийн төвд нийт 573 тээврийн хэрэгсэл үзлэг, оношилгоонд хамрагдаад байна. Бичигтийн боомтоор 431,6 мян баррел газрын тос, 87,9 тн хүрэн нүүрс, 956,7 тн төмрийн хүдэр экспортолсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Энэ сард байгаль орчны тэмдэглэлт өдрүүд болох Байгалийн амьтан, ургамлыг хамгаалах өдөр 3 сарын 3, Дэлхийн ойн өдөр 3 сарын 21, Дэлхийн усны өдөр 3 сарын 22 зэрэг өдрүүдэд тохиосон. Дэлхийн усны өдрийг энэ жилийн хувьд “УСНЫ ҮНЭЛЭМЖ, ҮНЭ ЦЭНЭ” уриан дор дэлхий нийтээрээ тэмдэглэж байна. Сүхбаатар аймгийн БОАЖГ-аас Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд

нэгдсэн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагуудтай /Дөрвөлж ОНӨААТҮ, Буйр нуур Мэнэнгийн тал сав газрын захиргаа\ хамтран боловсруулж батлуулан, холбогдох ажлыг зохион байгууллаа. Нэгдсэн төлөвлөгөөнд нийт 11 ажил тусгагдсаныг 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүллээ. Энэ жилийн хувьд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан халдвар хамгааллын дэглэмийг сахин цахим орчинд төлөвлөсөн ажлыг гүйцэтгэсэн.

Дэлхийн усны өдрийн хүрээнд аймгийн хэмжээнд BBS ТВ-д 6 удаагийн мэдээ, Подкаст чөлөөт нэвтрүүлэг 1, Инженерийн зөвлөгөө цувралаар 6 удаа, мөн Өнөөдөр тусгай нэвтрүүлэг 1, ЕБС-ийн сурагчдад нийт 11 удаагийн сургалтыг зохион байгуулж 396 сурагч, мөн Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх сургалтад 52 төрийн албан хаагчдыг хамруулсанаас гадна 9 төрлийн шторк, 2 төрлийн урсдаг зарыг өдөрт 12 удаагийн давтамжтай цацаж, байгууллагуудын фейсбүүк хуудсанд 87 удаагийн постор мэдээллийг оруулахад 172667 иргэний хандалт авсан байна. Тэмдэглэлт өдрийн хүрээнд нийт 6 төрлийн тэмцээн уралдааныг хүүхэд багачууд олон нийтийн дунд зохион байгуулж ажилласан байна. Үүнд: Видео шторк 3 \Дөрвөлж ХХК, БОАЖГ, Уулбаян, Дарьганга\, гар зураг 2 \Дарьганга, Түвшинширээ\, Эссэ бичлэг 3 \Асгат, Онгон, Түвшинширээ\, цахим хичээл заах уралдаан 1 \Баяндэлгэр\, Алтан хонх тэмцээн 1 \Наран сум\ зэрэг уралдааныг цахим орчинд зохион байгуулж шагнаж урамшуулсан байна.

3-р сарын 03 нд Дэлхийн зэрлэг амьтан ургамлыг хамгаалах өдрийг тохиолдуулан аргал хонины тооллого хийж био техникийн арга хэмжээ авч 20 боодол өвс тавьж өглөө. Нийт 34 тооны аргаль хонь тоологдлоо.

Зургаа. Батлан хамгаалах салбарт

Зэвсэгт хүчний Жанжин штабаас зарласан "Монгол Улсын Зэвсэгт хүчин 100" сэдэвт гар зургийн уралдааны талаарх мэдээллийг орон нутгийн телевиз, цахим хуудас, группүүдээр дамжуулан аймаг, сумдын ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчид болон их дээд сургуулийн оюутан залуусын дунд гар зургийн уралдааныг зарласан. Тус уралдаанд МУБИС-ын нэгдүгээр дамжааны оюутан Э.Даваажавын "Монгол цэрэг үүрд мөнх, Монгол цэрэг дэлхийн цэрэг" сэдэвт бүтээл Дүрслэх урлагийн мэргэжлийн оюутан ангилалд "Тусгай байр" эзэлсэн байна.

"Монгол цэргийн өдөр" орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулсан хөтөлбөр төлөвлөгөөний дагуу Төрийн цэргийн байгуулга, ҮАБТЧҮБ-уудын дунд Буудлагын тэмцээнийг "9мм ПМ гар буу, 7.62мм Автомат бууны" төрлөөр явуулж дүгнэсэн ба Их Жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд хүндэтгэл үзүүлэн цэцэг өргөх үйл ажиллагаа, Монгол Цэргийн өдөр орчин цагын Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярын хурал, Сүхбаатар аймгийн Цэргийн хүрээний "Нэгдсэн туяа тоо"-г тус тус зохион байгууллаа. Мөн Монгол хүн сансарт ниссэний түүхт 40 жилийн ойг тохиолдуулан тус түүхэн цаг дор мэндэлсэн одоогоор Сүхбаатар аймагт ажиллаж амьдарч байгаа 1 иргэнд хүндэтгэл үзүүлж Засаг даргын дурсгалын гарын бэлэг гардуулан хүндэтгэл үзүүлэв.

Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил

Баруун-урт:

Байгаль орчин: Хаврын хуурайшилтын улирал эхэлж буйтай холбогдуулан ахуйн болон хээрийн гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн

ОБГ-тай хамтран “Гал түймэр унтраах, аврах 15-р ангийн үйлчлэх хүрээний зам гарц, мухар гудамж, алслагдсан объект, нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийг батлуулан 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд 1-9 дүгээр багийн айл өрхөөр орж ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх, ажлыг зохион байгуулж байна. Үүнд баг хариуцсан ОБГ-ын аврагч нар ажилласан.Хээрийн түймэр гарах үед дайчлагдах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн аврах бүлгийн 40 албан хаагчийг 4 бүлэгт хуваарилан үүрэгжүүлэн бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллаж байна.

Хотын эргэн тойронд үүсээд байсан эзэнгүй хог хаягдал, малын сэг зэмийг устгаж ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах тухай сумын Засаг даргын 2021 оны А/71 дугаар захирамжийн дагуу аймгийн БОАЖГ, Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар, Мал эмнэлгийн газартай хамтран гүйцэтгэж байна. Цэвэрлэгээний ажилд нийт 1.6 сая төгрөг зарцуулагдсан ба 3 машин техник, 8 хүн ажиллаж байна.

Иргэдэд байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн боловсрол олгох сургалт чиглэлээр тэмдэглэлт өдрүүдэд ард иргэдэд сурталчилан таниулах ажлыг хийсэн. 03 дугаар сарын 18-ны өдөр” Хөшөө дурсгал хамгаалах өдөр”, 03 дугаар сарын 21-ний өдөр “ Дэлхийн ойн өдөр”, 03-р сарын 22-ны өдөр“Дэлхийн усны өдөр”, 03-р сарын 23-ны өдөр “Дэлхийн цаг уурын өдөр” тохиож байна. Энэхүү өдрүүдийг тохиолдуулан Баруун-Урт цахим хуудсаар дамжуулан “Усаа хайрлан хамгаалъя”, “Хөшөө дурсгалыг хамгаалах нь иргэн бүрийн үүрэг” зэрэг мэдээллийг хийж иргэдэд сурталчлан таниулсан.

Нохой устгах ажил гүйцэтгэх гэрээний дагуу Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазар нь 43 нохойг устгасан дүн мэдээг ирүүлсэн.

Сумын ИТХ-аар 2021 оны сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг батлуулсан. 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газрын дуудлага худалдааг 03-р сарын 10-ны өдөр “Хайлааст үүдэн” гэдэг газарт төмс хүнсний ногоо тариалах зориулалтаар 13 байршил, 03-р сарын 11-ны өдөр 10 байршилд зохион байгуулсан. Дээрх газрын дуудлага худалдаануудад 163 иргэн оролцсон байна.

Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: Хүнсний тээвэр эрхлэгч жолооч нарт мал, мах, малын тэжээл ачиж явахад QR код олгож байна. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 11 иргэн, аж ахуйн нэгжид олгосон.

Худалдаа эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг Хурлын дарга хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь сонссон.

Сумын аюулгүйн нөөцийн өвснөөс хаваржилт хүндэрч болзошгүй 872 өрхөд 6000 боодол өвс олгосон.

Баруун-Урт сумын ИТХ-ын дарга, сумын Засаг дарга нараар ахлуулсан ажлын хэсэг энэ сарын 14, 15-нд 8-р багийн малчин өрхүүд хаваржилтын бэлтгэл ажилтай танилцлаа.

Малчны хотонд зочлох үеэр малчид бэлчээрийн газраа хашихгүй байх, бэлчээрт гаргасан худаг ашиглалтыг сайжруулах мөн малчид хэсэг бүлгээрээ нэгдэн усгүй бэлчээрт гар хутаг гарган түүнийгээ дундаа хэрэглэх ,мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг үнэтэй байлгаж малыг эдийн засгийн эргэлтэд тогтмол оруулдаг байлгах зэрэгт анхаарч ажиллахыг хүслээ.

Нийгмийн хамгааллын чиглэлээр: Коронавирусээс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "КОВИДЫН ЭСРЭГ ХАМТДАА" уралдааныг Баруун-Урт сумын 18 хүртэлх насны иргэдийн дунд зарлаад байна.■

Улаанбаатар хотоос иргэд тогтмол ирж байгаатай холбоотойгоор тусгаарлах байрны эзэдтэй уулзаж шаардлагатай бэлэн байдлыг байнга хангах, хамтран ажиллах талаар ЭМГ, МХГ, ЦЕГ, ОБГ-ын албан хаагчаас бүрдэн ажлын хэсгийн хамт уулзаж зөвлөмж чиглэл өгч ажилласан.

Халдвартай бүс нутгаас ирсэн гэрийн тусгаарлалтад байгаа иргэдэд Тамгын газрын нийт албан хаагчид хуваарийн дагуу тогтмол хяналт тавин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 166 иргэн гэрийн ажиглалтад байгаа бөгөөд 165 иргэн гэрийн ажиглалтаас гарсан байна.

“Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан”-тай хамтран "It's Ok Not To Be Ok" төслийг хэрэгжүүлж байна.Төслийн хүрээнд мэргэжлийн сэтгэл зүйчтэй хамтран охид, эмэгтэйчүүд, гэр бүлд үнэ төлбөргүй сэтгэл зүйн зөвлөгөө өгч байна. Зөвлөгөөг долоо хоног бүрийн пүрэв гарагт цахим хэлбэрээр өгдөг бөгөөд нийт 11 иргэнд зөвлөгөө авсан.

Хууль эрх зүйн чиглэлээр:Архины хэрэглээг бууруулах, архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд сурталчлан, таниулах зорилгоор “Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөр боловсруулан сумын ИТХ-аар, 2021 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган сумын Засаг даргаар тус тус батлуулан ажиллаж байна.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар нь коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Шадар сайдын 2020 оны 3 дугаар сард баталсан Коронавируст халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журмын дагуу халдвартай бүс нутгаас ирсэн иргэнийг тусгаарлаж, ажиглалтад авах зорилгоор “Иргэнийг түр тусгаарлан ажиглах гэрээ” байгуулан ажиллаж гэрээний үүргээ биелүүлээгүй 10 иргэнийг Сүхбаатар аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид өгөөд байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээ, мэдээллийг боловсруулан бэлтгэж www.baruun-urt.su.gov.mn Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран, олон нийтэд хүргэж байна.

Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр: 3-р сарын байдлаар орон нутгийн болон төвлөрүүлэн захирагчийн харъяа төсөвт байгууллагуудын 2,609,806.7 мянган төгрөгийн /1000/ мөнгөн зарлагын гүйлгээнд хяналт тавин баталгаажуулсан.

Төрийн сангийн хувьд 254,224.9 мянга төгрөгийн татварын болон татварын бус орлого орж, татварын орлого төлөвлөгөө нь 60.7 хувьтай байна.

2021 онд Орон нутаг хөгжүүлэх сангаар хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу 7 тендер нээлттэй тендер, 8 тендер харьцуулалтын аргаар зарлан зохион байгуулагдаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаарх мэдээллийг орон нутгийн BBS телевизтэй хамтран иргэдэд мэдээлж ажиллаж байна.

АНУ-ын ОУ-ын хөгжлийн агентлагийн Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран Best

хөтөлбөрийн хүрээнд 8,840.0 мянган төгрөгийн санхүүжилттай “Бизнес төсөл боловсруулах, ур чадварыг нэмэгдүүлэх” сургалтад 80 иргэн, аж нэгж байгууллагуудыг хамруулсан. Тус сургалт нь бизнес төсөл боловсруулах, компанийн сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх, үр өгөөж, ач холбогдолын талаарх анхан шатны ойлголтыг олгосон.

Сум хөгжүүлэх сангаас төсөл хүлээн авах үйл ажиллагааг нээлттэйгээр зарлаж, орон нутгийн телевиз болон вэб сайтаар олон нийтэд мэдээлсэн.

Баяндэлгэр:

Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлыг хуралдуулж Монгол улсын төрийн дээд шагнал “Алтан гадас “ одонгоор 6 , “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 8 иргэнийг тус тус шагнуулахаар аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдэд хүргүүлэв.

Сумын ГХУСАЗЗ зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж ажлын төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталлаа.

Сумын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж ИТХ-ын дарга сумын засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгууллаа.

ИТХ, ЗДТГ хамтран “Дэлхий усны өдөрт” зориулан гар зургийн уралдаан зохион байгуулж 100.0 төгрөгний дэмжлэг үзүүллээ.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Сумын засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 04ны өдрийн А/31 тоот захирамжаар хорогдсон малын сэг зэм устгах халдваргүйтгэлийн ажлыг зохион байгууллаа.

Сумын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж байгууллагууд болон мэргэжилтэн нар 2021 онд хийх ажлын чиглэлээ танилцуулж Сумын засаг дарга албан байгууллагын дарга нартай хамтран ажиллах гэрээ, тамгын газрын дарга мэргэжилтэн нартай гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж гэрээг байгуулав.

Төсөв санхүүгийн чиглэлээр: Малчдыг зудын гамшгийн эрсдэлээс хамгаалах нийгэмлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу 40,0 тн тэжээл авчирж, малчдад хөнгөлттэй үнээр худалдан борлуулж байна.

Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Дэлхийн усны өдрөөр байгаль орчны тасгаас ерөнхий боловсролын сургуулийн 6-9 дүгээр ангийн сурагчдад усны үнэ цэнэ сургалтыг зохион байгуулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Ажил хайгч 12 иргэдийн мэдээллээ сэргээж 5 иргэн ажил хайгчаар бүртгэсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Халамжийн тэтгэвэр цахимд шилжиж байгаатай холбоотой 74 иргэний дансыг Хаан,Төрийн банкнаас дансыг авч утасны дугаарыг e halamj цахим системд оруулаад байна.

Бүрэн дунд сургууль: БШУЯСайдын А/53 дугаар тушаалын дагуу 2021 оны 03 сарын 22-ны даваа гаригаас эхлэн танхимын сургалтыг үйл ажиллагаа хэвийн

хуваарийн дагуу орж эхэллээ. Хичээл сургалт хэвийн орж эхлэсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн төвтэй хамтран 1, 2 дугаар хичээлийн байр, дотуур байр, урлаг спортын заал гэх мэт сургуулийн бүх объектод ариутгал халдваргүйжүүлэлт хийв.

ЕБС – нь “Би жэндрийн хэвшмэл ойлголтын эсрэг байна” аянд нэгдэж, аяны хүрээнд Монгол цэргийн баярыг тохиолдуулан байгууллагын эрэгтэйчүүдэд “Хөдөлгөөн эрүүл мэнд” уриалагтай сумынхаа фитнес төвд 1 сар үнэгүй хичээллэх эрхийн бичиг олголоо. Мөн энэ аяны хүрээнд Эрүүл мэндийн төвтэй хамтран 1-12 дугаар ангийн хөвгүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

ЯХИС, Дэлхийн банк, БСШУЯ, ХИС- аас хэрэгжиж буй хүүхэд залуучуудыг дэмжих “ Орон нутгийн хүүхэд залуучуудад хувь хүний чадвар олгох, энпренершип боловсрол олгох” төсөл хөтөлбөрт ЕБС-ийн 8-11 дугаар ангийн 24 сурагч сонгогдож сургалтын нээлтийг хийлээ.

Эрүүл мэнд: 3-р сард нийт үзлэгт 2250 хүн хамрагдсан. Больницод 36 иргэн хэвтэн эмчлүүлснээс хүүхэд 6 байна.

Сэргээн засах эмчилгээний кабинетаар 91 иргэн, лабораториор 25 иргэн үйлчлүүлээ. Амбулатороор үйлчлүүлж буй иргэдэд коронавирусын талаар зөвлөмж өгч гарыг ариутгаж халуун үзэж халвар хамгааллыг баримтлан ажиллаж байна.

Мөн Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын сурагчид, багш ажилчид, 11-дүгээр ангийн сурагчдад ариутгал халдваргүйтгэл гар угаах дараалалаар сургалт хийж гарын авлага тараах материал тараасан.

Бүрд ХХК-ийн монгол дахь төлөөлөгч М.Алтанцэцэг явуулын Рентген аппарат хандивласан нь аймгийн баруун өмнөд бүсийн сумдын иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамруулахад чухал хувь нэмэр орууллаа.

Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулан нийтийн эзэмшлийн талбай болон ногоон байгууламж албан байгууллага ААНэгжүүдийн эзэмшлийн талбай болон хуваарьт газруудыг цэвэрлүүлэн ажиллалаа. Мөн аймгийн засаг даргын албан даалгаварын дагуу сумын төвийг тойрсон хорогдсон малын 45 сэг зэмийг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн ариутгал халдваргүйжүүлэлтийг мал үржлийн тасагтай хамтран хийж гүйцэтгэсэн.

Ус бохирдуулагчийн төлбөрийн тухай хуулийг таниулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ус бохирдуулагч 9 ААН, байгууллагатай ус бохирдуулсаны төлбөрийг төлөх гэрээг байгууллаа.

Дэлхийн усны өдрийг угтан бөмбүүлэй хүүхдийн цэцэрлэгийн 9 бүлгийн багш нарын дунд “Усны үнэлэмж, үнэ цэнэ” уриалгын дор хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон сэдвийн дор нээлттэй хичээлийн уралдааныг зохион байгуулж шагналт байранд орёон багш нарыг шагнаж урамшууллаа. Мөн ерөнхий боловсролын сургуулийн эко бүлэг болон 9-12 ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан зохион байгуулж 32 хүүхэд оролцож 1,2,3 дугаар байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Ногоон алт- Малын эрүүл мэнд” төслийн хүрээнд “Баяндэлгэрийн

улаан” үүлдрийн ямааны ноолуурын чанарын үзүүлэлтүүдийн (голч, атираа, урт) өөрчлөлтийг өмнөх судалгааны дүнтэй харьцуулан судлаж ямаан сүргийн ажлын төлөвлөгөө боловсруулахад шалгуур үзүүлэлт болгох үүднээс аймгийн ХХААГ-ын Мал үржлийн албаны мэргэжилтнүүдтэй хамтран Дэлгэр, Дөхөм багийн 9 сууриас 60 ухна, 60 эм ямаанаас ноолуурын дээж авч ажилласан.

Сумын хэмжээнд том малын хорогдол бүгд -2747, адуу -55, үхэр-127, хонь-1052, ямаа-1513 нийт төллөсөн мал -1148, ингэ-11, гүү-5, үнээ-72, эм хонь-740, эм ямаа-320

Мал эмнэлэгийн чиглэлээр : Аймгийн мал эмнэлэгийн газраас шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 24,6 мян / тунг татан авчирч МЭҮН-үүдэд хуваарилан олгосон.

Аймгийн Засаг даргын 2021 оны 03-р сарын 03-ны өдрийн 02 тоот албан даалгавар, Сумын засаг даргын 03 дугаар сарын 04-ны өдрийн А/31 тоот захирамж гарч хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгууллаа.

Дарьганга:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын Засаг даргын захирамжаар “Хурдан морины уралдаанд хориг тавих тухай” асуудлыг зохицуулан зохион байгуулах арга хэмжээг авлаа.

Урин дулааны улирал эхэлж буйтай холбогдуулан үхсэн малын сэг зэм устгах ажлыг хийж эхлээд байна.

2020 оны архивын баримтыг эмхлэн, цэгцлэх ажлыг хийж, байнгын 8 ХН -406 хуудас, түр хадгалах 15 ХН-1436 хуудас, 70 жил хадгалах -2 ХН-70 хуудас буюу нийт 25 ХН 1912 хуудас материал архивлаад байна.

Сумын Засаг даргаар ахлуулсан “Хамтарсан баг” хуралдаж 2021 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлууллаа.

Сургалт сурталчилгааны чиглэлээр. 2021 оны эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсны дагуу сар бүрийн 3 дахь өдөр төрийн албан хаагчдад сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг тусгай удирдамжийн хүрээнд зохион байгуулж эхэлсэн. Үүний дагуу Нийгмийн даатгалын байцаагч, Хөдөлмөр нийгмийн халамжийн мэргэжилтэн, Хэсгийн төлөөлөгч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар сургалтуудыг зохион байгууллаа. 90 хүн оролцлоо.

БОАЖЯ-ны ТХБНУГ-аас зохион байгуулсан "Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй" онлайн сургалтанд хамгаалалтын захиргааны дарга мэргэжилтэн нар хамрагдлаа.

“ ХҮҮХЭД ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭЭРЭГ АРГА” сэдэвт сургалтыг БСУГ-н СӨБ хариуцсан мэргэжилтэн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш туслах багш нарт цахимаар зохион байгуулж, 15 албан хаагчийг хамрууллаа.

Сургууль, цэцэрлэг:Онцгой нөхцөлд сургалт үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан гарсан “Улсын онцгой комиссын” даргын 2021 оны 02 дугаарын сарын 22 ны өдрийн А/18 тоот, “Монгол улсын БШУС-ийн А/58 дугаар тушаалуудын дагуу байгууллагын анги танхим болон гадаад орчинг цэвэрлэж халдвар хамгаалалтын арга хэмжээг авч ариутгал халдваргүйтлийг хийж ажиллаж байна. Мөн хүнсний бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэн мах, сүү, сүүн бүтээгдэхүүнд мал эмнэлгийн

шинжилгээний бичгийг авч , Цэцэрлэгийн байранд бөөгнөрөл үүсгэхгүйгээс сэргийлж, өдрийн дэглэмд өөрчлөлт оруулж, хүүхэд хүлээн авах тарах цагийг уян хатан байлгах, орох гарах бүх хаалгыг ашиглаж ажиллаж байна. Цэцэрлэгт хамрагдаж байгаа 130 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулж үзлэгийн хуудас бөглүүлсэн.

ЕБСургуулиас: Дэлхийн яруу найргийн өдрийг угтаж хүүхэд бүрийг нутгийн зохиолчдыг шүлэг өгүүллэг намтар уран бүтээлийг сайн таниулах зорилгоор төв номын сангаас зохион байгуулсан “Нутгийн зохиолчдын шүлгийг хэн сайн унших вэ” уралдаанд нийт 20 хүүхдийг бэлгэж цахимаар видео бичлэгийг явуулсан.

Сургуулийн номын сангаас зохион байгуулсан **“Ээждээ хүргэх сэтгэлийн үгс”** уралдаанд нийт 69 хүүхэд хамрагдаж, эхний 8 байрыг шалгаруулж дурсамж, бэлэг дургалын зүйлийг гардуулсан

Эрүүл мэнд: Засгийн газрын 224-р тогтоолын дагуу “Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд”, “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд”, “Дэлхийн усны өдөр”, “Давсны 7 хоног” зэрэг арга хэмжээг цаг үетэй холбогдуулан цахимаар мэдээ мэдээлэл, сурталчилгааг байршуулан олон нийтэд хүргэсэн.

ЕБС-ийн 4 ангийн 72 сурагч, цэцэрлэгийн 3-5 насны 120 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулаад байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Манлай малчин холбоонд улс, аймаг, сумын сайн малчид болон ажил үйлсээрээ бусдыг манлайлж байгаа 100 малчин өрхийн судалгааг хүргүүлсэн.

Сумын нөөцөөс 2900 боодол өвс малчдад тараасан.

2 дугаар багийн 35 хот айлын 102 малчинд бог малын хээлтүүлэгчийг үржлийн нэгжид шилжүүлэх арга хэмжээг авлаа. 2

Байгаль хамгаалах чиглэлээр: Аймгийн Засаг даргаас сумын засаг даргатай байгуулсан гэрээнд Ховор ан амьтанд био техникийн арга хэмжээ авах заалтын дагуу Нартын ууланд олон жил нутагшсан 30 гаруй аргальд 20 боодол өвсийг бэлчээрт нь тавьж өгсөн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар албан даалгавар Сумын Засаг даргын 2021 оны 31 дүгээр захирамжийн хэрэгжилтийн хангах зорилгоор сумын төвийн эргэн тойронд болон, 1-р багийн Үүдийн ШҮҮ-ний орчмын үхэж хорогдсон мал амьтны сэг зэмийг цэвэрлэх устгах ажлыг зохион байгуулсан. Бог малын сэг зэм 25, бод малын сэг зэм 15 ширхэгийг утсгаад байна.

Хууль бусаар ан агнах, мод бэлгэх гэмт хэрэг, энэ төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх зорилгоор Экологийн цагдаагийн албанаас зохион байгуулсан “ЭКО-2021” аяныг 02 сарын 01 нээс 03 сарын 15-ны өдрийг хүртэл явуулаа. Энэ ажлын хүрээнд Дарьгангын БЦГ-ын хамгаалалтын захиргаа экологийн цагдаатай хамтран ТХГН-аас мод бэлтгэн түлшиндээ хэрэглэсэн, хууль бус ан хийсэн гэсэн мэдээллийн дагуу хяналт шалгалтын ажлыг хийж, ТХГН-т орших Өргөн голын бургаснаас 2 куб мод түлшиндээ хэрэглэсэн, бор хөндийд 2 цагаан зээр агнасан, Шилийн богд уулын орчимд 1 цагаан зээр, 1 бор гөрөөсийг агнасан байсныг илрүүлж, эрүүгийн хэрэг үүсгэсэн.

“Тусгай хамгаалалттай газар нутагт мөрдөгдөх нэгдсэн өнгө төрх, загварыг батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 12 дугаар сарын 11-ний

өдрийн А/489 дугаар тушаал, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тэмдэг тэмдэглэгээ, дүрэмт хувцас, Ерөнхий шаардлага MNS 5851:2008 стандарт-д нийцүүлэн, Алтан овоо, Шилийн богд уул орчмын өвөрмөц тогтоц өнгө төрхийг алдагдуулахгүйгээр, байгаль орчинд ээлтэй байдлаар хэрхэн тохижуулах талаар орон нутгийн удирдлага болон төрийн албан хаагчид, иргэдээс санал авах хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлт гарсан үр дүнг нэгтгэн аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар Усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө боловсруулж ЕБС-ийн сурагчдийн дунд “Усны үнэлэмж - үнэ цэнэ” сэдэвт видео уриалгын уралдаан болон гар зургийн уралдааныг зохион байгуулж дүгнэсэн.

Нийгмийн халамжийн талаар: АДЗ-ийг 2 удаа хуралдуулж амьжиргааг дэмжих 27 өрхийг хэлэлцэн баталсан. Мөн ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүлдээ асран хамгаалж байгаа иргэний асаргааны тэтгэмжийг хэлэлцсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж байгаа дэлгүүрийн гэрээг сунгаж, 2-р сарын тайлан мэдээ болон худалдан авсан бүтээгдэхүүний бүртгэлийг хүргүүлж, 3-р сарыг хүнсний эрхийн бичгийг олгож эхэлсэн.

Мөнххаан:

2020 оны сумдын үйл ажиллагааны үнэлгээгээр тус сум Дэд байр эзэлж шагналаа гардан авлаа.

Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг төсвийн байгууллагуудад ажиллалаа.

Улсын бүртгэл: Төрсний 8, гэрлэсний 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 3, иргэний үнэмлэхний олголтын бүртгэл 11, хүчингүй болгосны бүртгэл 1-ыг тус тус бүртгэсэн. Шилжилт хөдөлгөөний бүртгэл 16-аас дээш насны 4, доош насны 3 иргэний бүртгэлийг тус тус хөтөлсөн. Иргэний улсын бүртгэлийн лавлагаа 5 иргэнд олгосон нийт 33 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

Гамшгаас хамгаалах чиглэлээр: Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339,340 дүгээр тогтоолын хүрээнд хийгдэх нэгдсэн дадлага сургуулилтыг 2021 оны 03-дугаар сарын 25 ны 16 цаг 00 минутад Мөнххаан сумын хэмжээнд Монгол улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолын баримтлан зохион байгууллаа. Уг арга хэмжээнд сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги шуурхай бүлгийн 83, нийт 133 төрийн албан хаагчид хамрагдан бэлэн байдлыг ханган ажиллалаа.

Нийгмийн бодлогын хүрээнд:

Эрүүл мэндийн чиглэлээр: 03 сарын 26 -ны байдлаар 41 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 27 насанд хүрэгчид, 14 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн. Амбулаторийн үзлэг 670 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 238 байна.

Сүрьеэгийн талаарх мэдээ мэдээллийг цахимаар болон гарын авлагаар мэдээлэл иргэдэд тарааж нийт 150 хүнд мэдээ мэдээлэл хүргэсэн. Түргэн тусламжийн дуудлага 71 ирснээс алсын дуудлага - 6, ойрын дуудлага 65 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Соёлын төв Номын сангийн явуулын үйлчилгээг 25 иргэнд хүргэн 98 номоор үйлчилсэн. Номын сангийн танхимаар 96 сурагчдад 250 гаруй номоор үйлчиллээ.

Уран бүтээлийн тоглолт нэгдсэн арга хэмжээ 2 удаа зохион байгуулагдаж 360 иргэд үзвэрийн танхимаар үйлчлүүлсэн байна. Номын сан иргэдэд соёл олон нийтийн ажил 2 удаа, цахим мэдээ мэдээлэл 22 удаа хүргэж ажиллалаа.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас зээл авсан, эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн иргэдэд мэдээлэл хийж 9 иргэнд мэдэгдэл өгч гарын үсэг зуруулсан. Утсаар 4 иргэнд эргэн төлөлтийн хуваарийг танилцуулж хугацаандаа төлөхийг сануулсан.

Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр: ОНОТХҮ-ний төсөл зарлагдсантай холоотойгоор Мөнххаан сумын зар зарлалын нэгдсэн групп нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн.

2021 онд хөгжүүлэх 30 өрхийг багийн засаг дарга нараас тус бүр нь 10, нийт 50 өрхийн жагсаалт авч амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцэн ХХҮГазарт жагсаалтыг хүргүүлсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр 59 иргэнд ehalamj системээр олгогдсон. Олголтыг тулган баталгаажуулж Илүү татагдсан 2 иргэний 29032 төгрөгийн буцаан татуулсан.

ХЭБҮ-гээр 69 өрхийн 315 иргэний 3,760,000 төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

Мал эмнэлгийн болон ХХАА-н чиглэлээр: Сумын мал эмнэлгийн тасаг, хөдөө аж ахуйн тасаг, байгаль орчны тасаг, багийн Засаг даргатай хамтарч сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажлыг эхлүүлээд байна. Сумын төв ойролцоо хаясан бод малын 35, бог малын 26 малыг сэг зэмийг цуглуулан хогийн нэгдсэн цэгт төвлөрлүүлэн хаяж халдваргүйтгэл хийгээд байна.

Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр: Сумын хэмжээнд дэлхийн усны өдрийг “Усны үнэлэмж” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу БОАЖГ болон Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвөөс “Ой модны ашиг тус”, “Ус ба түүний зохистой хэрэглээ” сэдвийн хүрээнд цахим сургалтанд “Эко клуб”-ын 11 сурагчдыг хамруулсан.

Газар зохион байгуулалтын чиглэлээр: Газрын кадастрын системд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 17 өргөдлийг цахимаар хүлээн авч сумын Засаг даргын захирамжаар газар олголт хийн гэрчилгээг олгоод байна.

ГХБХБГ-ын даргын 03/19 ны өдрийн 1/17 тоотын дагуу газрын төлбөрөө хугацаандаа төлөөгүй болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 жил дараалан газраа ашиглаагүй нэр бүхий 7 иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийг цуцалж мэдэгдэл хүргүүлж ажилласан.

Онгон:

Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Сумын ИТХурлын тэргүүлэгчид 1 удаа хуралдаж багийн Иргэдийн нийтийн хурлын товыг зарлалаа.

Хууль эрх зүй: ЕБС-ийн Алимхан эко клубын сурагчидтай хамтран усны ухаалаг, зүй зохистой хэрэглээг сурталчлан таниулах зорилгоор усны зохистой хэрэглээний талаархи зөвлөмжийг нийт 120 иргэнд тарааж хууль, эрх зүйн мэдээлэл хүргэсэн.

Боловсрол: Сургуулийн танхимаар хичээллэх ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан халдвар хамгааллын дэглэм сахиулах ажлын хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

Нийгмийн халамж: Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж 13 иргэний материал хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргалаа.

Соёл: Цар тахлын үед олон нийтийн арга хэмжээг хориглосонтой холбогдуулан соёлын төвөөс Эмэгтэйчүүддээ зориулсан цахим дууны уралдаан, Эх орны төлөө цахим дууны уралдаануудыг зохион байгуулж 76 иргэн оролцож дүнгээ гарган шалгарсан иргэдийг шагнаж урамшууллаа.

Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Аймгийн Хөдөө аж ахуйн холбогдох албан хаагчидтай хамтран ноолуурын дээж авах ажилаар 2 багийн 6 малчин өрхөөр явж ажиллаа.

Богийн хээлтүүлэгч малыг хөдөөгийн гурван багт тусгаарлан хариуцлах арга хэмжээ авлаа.

Дэлхийн ойн өдөр болон , Дэлхийн усны өдрийн хүрээнд Цэнгэг ус байгаль хамгаалах төвөөс сум орон нутгийн Эко клубын хүүхдүүдийн дунд зохион байгуулсан "Ус ба түүний зохистой хэрэглээ", "Монгол орны ой сэдэвт" сургалтанд Алимхан эко клубын сурагчидыг хамрууллаа Сургалтанд нийт 18 сурагч хамрагдсан болно.

Сүхбаатар:

Төрийн удирдлагын чиглэлээр: Захиргааны байгууллагын үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан "Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ сэдэвт сургалтад 32 албан хаагч хамрагдсан.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын нутаг дэвсгэрт гарсан хээрийн түймэр унтраах ажилд сумаас 2 бүлгийн 25 хүн, Онцгой байдлын газраас 2 бүлэг, нутгийн малчид, Дорнод аймгийн ОБГ, Булган сумаас 2 бүлэг нийт 100 гаруй хүн ажиллаж, цурманд оруулсан ба хохирол тогтоох ажлын хэсэг тус газарт ажиллаан. Уг түймэрт нийт 8250 га газар шатаж байгаль экологид 54.573750₮ төгрөгний хохирол нийт- 56.513350₮ төгрөгний хохирол учраад байна.

Сумын нэгдсэн хогийн цэгийг ландфиллын аргаар булшлах ажлын бэлтгэлийг хангах хүрээнд зураг төсөв боловсруулах, хогийн цэгийн га хэмжээг тогтоох ажлыг аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнээр хийлгэж байна.

Дархан хаан ууланд нутагшиж байгаа Аргаль хонинд өвөлжилт, хаваржилтын талаар мониторинг хийж, хог хаягдлыг цэвэрлэсэн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Нийт үзлэг – 550, Урьдчилан сэргийлэх үзлэг – 245, Амбулаторийн үзлэг – 272, Идэвхитэй хяналт – 7, Гэрийн дуудлага – 26, Яаралтай түргэн тусламжийн дуудлага – 53, Алсын дуудлага – 27, Халдварт бус өвчлөл эрт илрүүлэг үзлэг – 110

ЕБС-ийн 6 а, б ангиудад Зөв дадал хэвшлийн талаар сургалт зохион байгуулж, 43 хүүхэд хамрагдсан.

Соёл урлагийн чиглэлээр: Жил бүр уралмжлал болгон зохион явуулдаг “Ижийдээ захидал бичээрэй” захидлын уралдаанд насан хүрэгчдийн төрөлд 13 хүн оролцож, хүүхдийн төрөлд 9 нийт 22 хүн хамрагдсан.

Монгол улсын зэвсэгт хүчин байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан эр цэргийн яруу алдарыг магтан дуулах зорилгоор “Аавдаа захидал бичээрэй” анхдугаар уралдааныг насанд хүрэгчид болон хүүхэд гэсэн 2 төрлөөр зохион байгуулж шалгарсан эхний 3 захидлыг уншиж видео болгон цахимд байршуулсан нийт 27 хүн оролцсон.

Мөн хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлж хамгаалах, тэдний дотоод ертөнц, хүсэл мөрөөдөл, санал санаачлагыг гар зургийн бүтээлээр дамжуулан нийгэмд хүргэх зорилготой ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ хүүхдийн гар зургийн уралдааныг зарлаж бүтээлийг хүлээн авч байна.

Түвшинширээ:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын удирдах ажилтны зөвөлгөөнийг 3 дугаар сарын 22-нд зохион байгуулж, сумын удирдлагууд болон багийн Засаг дарга нар, байгууллагуудын дарга эрхлэгчид, ЗДТГ-ын мэргэжилтнүүд нийт 32 хүн оролцлоо. Зөвлөгөөний төгсгөлд сумын Засаг дарга байгууллагын дарга эрхлэгчид болон багийн Засаг дарга нарын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталлаа.

Сумын ИТХ-ын шийдвэрийн дагуу багуудын иргэдийн нийтийн хурлууд хуралдаж багийн Засаг дарга нарыг сонгоод байна.

2021 оны 03 дугаар сарын байдлаар сумын нийт хүн ам 3412, сумын нийт өрх 975 байна.

Хүүхдэд тавих хараа хяналтыг чангатгах, бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь үлдээхгүй байх, ахуйн хүрээнд архи дан согтуурахгүй байх, гэр бүл, үр хүүхдээ эрсдэлд оруулахгүй байх талаарх зөвлөгөө зөвлөмжийг ЕБС, СӨБ-ын багш нартай хамтарч цахимаар видео контент бэлтгэн тархааж байна.

Төрийн албан хаагч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт 32 эрэгтэй төрийн албан хаагчийг хамруулж, эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөөг ЭМТ-ийн эмч нараар өгүүлсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: ХХОАТатварын хөнгөлөлтөнд нийт 29 иргэнээс тайланг цахимаар хүлээн авсан ба сургалтын төлбөрөөр 15 иргэн, шинэ орон сууцны хөнгөлөлтөнд 3 иргэн, давтан орон сууцны хөнгөлөлтөнд 11 иргэн хамрагдаад байна. Орон сууцны хөнгөлөлтийн буцаан олгох дүн 7530,1 мянган төгрөг, сургалтын төлбөрийн буцаан олгох дүн 2664.4 мянган төгрөг буцаан олгохоор байна.

Сүхбаатар аймагт түүврийн аргаар 1376 ширхэг машиныг татвар төлөхгүйгээр татварын бүртгэл болон авто тээврийн үндэсний төвийн мэдээллээс хасуулах боломжтой жагсаалтанд манай сумаас 45 машин орсон ба үүнээс 25 машиныг хасуулахаар бичиг баримтыг нь бүрдүүлж мөн ашиглахаа больсон 10 мотоциклийн татварыг бүрэн төлүүлж татварын өргүй болгон хасалт хийлгэхээр аймгийн татварын хэлтэст хүргүүлэн ажилласан.

Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг байгуулан “УСНЫ ҮНЭЛЭМЖ” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ус ба эрүүл мэнд усны савны эрүүл ахуйн стандарт ус хадгалах савны талаарх мэдээллийг хүргэж ажилласан. ЕБСургууль нь 2021 оны 03-р сарын 22 ний өдрийн эхний хичээлийг нийт ангиудыг хамруулан усны талаарх мэдээ мэдээлэл зөвлөмжийг

сурагчдад хүргэж ажилласан. “УС БОЛ АЛТ” гар зургийн уралдааныг 1-3, 4-6 ангийн дунд зохион байгуулан эхний 3 байрыг шагнаж урамшуулсан. “ДУСАЛ УС БИДНИЙ АМЬДРАЛД” сэдэвт зохион бичлэгийн уралдааныг 7-11 ангийн дунд зохион явуулж тус бүр эхний 3 байрыг шалгаруулсан.

Сумын хэмжээнд хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох санал асуулгыг оруулж нийт 320 өрхөөс санал асуулга авсан.

Сум хөгжүүлэх сангийн зээлээ бүрэн төлж барагдуулсан 5 иргэн 10,2 сая төгрөг, 3 иргэн 2,3 сая төгрөгний төлөлтийг хийгээд байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д бүртгэлтэй ажил хайгч 2021 оны 03-р сард хөдөлмөрийн насны ажилгүй иргэн ажил хайгчаар 2 иргэн, "Ажилд орсон иргэн"-ийг ажлын байрын зуучлалд-6 иргэн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

2017-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан төсөл хөтөлбөрт хамрагдсан 13 иргэний 1396250 төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийлгэхээс 7 иргэн 806250 төгрөг, 6 иргэн 590,000 төгрөгний эргэн төлөлтөө хугацаа хэтрэлттэй ба сар бүр иргэдтэй холбогдон мэдэгдлийг өгснөөр хугацаа хэтэрсэн төлөлтийг бүрэн хийлгэх талаар арга хэмжээ авч ажиллаж байна.

2021 оны 03 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан 11 иргэнд 1116350 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган бэлтгэн өгсөн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 26 өрхийн 117 иргэн хамрагдаж байгаа ба 03-р сарын 1,448,000 төгрөгийн "Хүнсний бүтээгдэхүүн худалдан авсан бүртгэл"-ийг гэрээт дэлгүүрт бэлтгэн өгч өрхүүдэд олгуулж байна.

"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр цахимд шилжсэнтэй холбогдуулан ehalanj системд Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй 3 ахмад болон тахир дутуугийн тэтгэвэр авч буй 54 иргэн нийт 57 иргэний данс, утасны дугаарыг мэдээллийг бүртгэсэн.

2021 онд амьжиргааг дэмжих 27 өрхийг сонгож сумын Засаг даргаар батлуулж хурлын тэмдэглэлийн хамт ХХҮГ-т хүргүүлсэн.

3-р сард ЭМД-д 18 хүний 1148.4 төгрөг, СДД-д 21 хүний 989050 төгрөг төвлөрүүлэв. НДШ-д 3-н байгууллагын 424200 орлого орж байна. 02 сарын тэтгэвэрт 2 банкаар 411 хүнд 143856026 сая төгрөгний тэтгэвэр олгосон. Тэтгэмжд 5 хүнд 6916989 төгрөг олгосон.

ЕБС: Хичээл сургалтын үйл ажиллагааг явуулахдаа Ковид-19-өөс сэргийлэх халдвар хамгааллын дэгдэм барин ажиллаж байна. БШУСайдын А/58 түр тушаалын дагуу хичээл сургалтын үйл ажиллагаа танхимаар орж байна. 1,2,5-р ангийн давтлага хичээл II/18-III/01 хүртэл бүх ангиудад монгол хэл, математикийн давтлага хичээл, танхимаар орсон тул 30-аас дээш хүүхэдтэй 3-5-р ангиудыг дэд бүлэг болгож 2 ээлжээр орууллаа.

Багш нар сурлагын хоцрогдол арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, сурагчдын ажиглах судалгаа гаргаж ажиллаж байна. 2-5-р ангиудад “Зөв цэвэр бичигтэй” анги хамт олныг шалгаруулах массын уралдаан явагдаж байна. 1-2-р ангиудад “Жимстэй уншлага” хийж сурагчдын унших чадварын үнэлгээ хийж АУБ нарт үүрэг даалгавар зөвлөгөө өглөө.

Монгол бичгийн сургалтыг анхан, дунд, ахисан шатанд зааж удирдлагууд, багш, ажилчид бүрэн хамрагдаж байна.

Хүүхдийн цэцэрлэг: Хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгт 203 хүүхэд буюу 88.3% хамрагдлаа. Үүнээс улаан бурхан, гахай хавдарт 28 хүүхэд, халдварт ангиний нэмэлт вакцинд 175 хүүхэд хамрагдаж, шүдний өвчтэй 42 хүүхэд, томуу- 6, бусад -1 хүүхэд өвчилсөн.

Бүх бүлгийн хүүхдийн эрсдлийн судалгаа болон зайнаас хичээлээ үзэж байгаа 25 хүүхдийн судалгаа гаргалаа.

Соёлын төв: Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж “Миний ээж” цахим дууны уралдаан, “Хайртай шүү ээжээ” захидлын уралдаан, нутгийн яруу найрагч, зохиолчдыг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд МУСТА, АБТА, МЗЭ-ийн гишүүн зохиолч, яруу найрагч Ч.Төмөртоогогийн уран бүтээлээс хүргэх зэрэг ажлуудыг хийсэн. Уралдаануудад нийт 60 гаруй оролцогч оролцсон байна.

Орон нутаг судлах танхимыг тохижуулах ажлыг эхлэхтэй холбогдуулан нийтэд сурталчлах зорилгоор Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсны 100 жилийн ой буюу цэргийн баяраар сумын бахархалт, түүхт хүн ахмад дайчин Ашийн Дугарын намтар гавьяаг өөрийн байгууллагын болоод сум орон нутгийн цахим группээр танилцуулан сурталчлах ажлыг зохион байгуулсан. Мөн “Түүх соёлын өлгий Түвшинширээ нутаг минь” эссэ бичлэгийн уралдааныг зарлаад байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Амбулаторийн нийт үзлэг 207, алсын дуудлага 13, гэрийн дуудлага 8, хэвтэн эмчлүүлэгч 7, Угтах лавлах үйлчилгээгээр нийт 235 иргэн үйлчлүүлээд байна.

Цэцэрлэг сургуулийн нийт 327 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, өвчлөлийг эрүүлжүүлэх арга хэмжээ авсан.

Эрүүл мэндийн сайдын 375 тоот тушаалын дагуу давхардсан тоогоор 51 удаа аж ахуй нэгж байгууллагуудад тандалт судалгаа хийсэн байна.

3-р сард хөдөөгийн 4 багийн хуралд баг хариуцсан эмч нар явж халдварт өвчнөөс сэргийлэх, зөвөлгөө өгч нийт 218 хүнийг артерийн даралт, чихрийн шижин, хөхний үзлэг, эсийн шинжилгээнд хамруулсан.

Хууль эрхзүйн чиглэлээр: “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” “Хүүхэд хамгааллын тухай хууль” “Ковид-19 зөвлөмж” гарын авлагуудыг бэлтгэн хэвлэж сумын иргэд болон аж ахуйн нэгжүүдэд тараан сурталчилсан.

Багийн иргэдийн нийтийн хуралд ЗДТГ-ын болон босоо удирдлагатай мэргэжилтнүүд оролцож өөрсдийн чиг үүргийн дагуух хууль дүрмийн талаар яриа танилцуулга хийж ажилласан.

Түмэнцогт:

Төрийн удирдлагын чиглэлээр:

- Засаг даргын зөвлөлийн хурлаар Засаг даргын дэргэдэх албад, төсөвт байгууллагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцүүлж гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталлаа.

- Хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан ил тод мэдээллээ.

- Төрийн үйлчилгээний оператороос 19 лавлагаа 6 төрлөөр гаргаж үйлчилсэн байна.

- Сумын төвийн ойролцоо эзэнгүй сэг зэм, нийтийн эзэмшил газрын хог хаягдал цэвэрлэх ажлыг 80 гаруй төрийн албан хаагчид, 90 гаруй ЕБСургуулийн хүүхдүүд оролцон хамтран зохион байгууллаа.

Байгаль орчны чиглэлээр: Дэлхийн усны өдөр тохиож байгаатай холбогдуулан зохион байгуулсан арга хэмжээнд ЕБСургуулийн 7 ангийн 8 бүлэг, дотуур байрны 20 гаруй сурагч, Цэцэрлэгийн 3 ангийн 5 бүлэг, төсөвт байгууллагын 3 албан хаагч хамрагдаж, 17 бүтээл ирүүлсэний зэрэгцээ уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 ААН, 970 гаруй иргэнд мэдээлэл хүргэж ажиллалаа.

Энэ сард уул уурхайн ашигласан усны төлбөр болох 4,1 сая төгрөгийг татварт төвлөрүүлэн хяналт тавьж ажиллаж байна.

ХАА чиглэлээр: Сумын хэмжээнд том малын зүй бусын хорогдол тэмээ – 1, адуу – 193, үхэр - 496, хонь -1130, ямаа – 1239, нийт – 30319 толгой мал хорогдож сумын нийт малын 2.2%-ийн хорогдолтой байна. Мөн мал төллөлт 4,9%-тай байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Соёлын чиглэлээр: Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Шүлэгт мэндчилгээг баярын өдөр Түмэнцогт Соёлын төв цахим хуудсаар дамжуулан хүргэлээ.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ардын урлагийг сурталчлах, өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сумын эмэгтэй дуучид, шинэ залуу ардын авьяастныг тодруулан, тэднийг урамшуулж, хөхүүлэн дэмжих зорилгоор ДҮҮРИЙМАА ардын дууны уралдааныг эмэгтэйчүүд, ардын авьяастануудын дунд зохион явууллаа

Номын сангийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Энэ сард нийт 38 уншигчдад 54 ш ном, үүнээс насанд хүрэгчдэд 17 иргэнд 26 ш, 21 хүүхдэд 28 ш ном олгож үйлчиллээ.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "ТОРГОНЫ ХЭЭ" урлагтай уулзалт арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний зочноор Түмэнцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Х.Мөнхчимэг, Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн дүн бүртгэгч, спортын мастер Ч.Сумъяагэрэл, СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуулийн оюутан, Хатантуул хамтлагийн бүжигчин Э.Алдармаа нар оролцож бүсгүйчүүдэд өөрсдийн талаарх илтгэл, чөлөөт ярилцлагыг зохион байгууллаа

Хөдөлмөр, нийгмийн халамжийн чиглэлээр:

- Сумын иргэдэд Хөдөлмөр эрхлэлт болон Халамжийн чиглэлээр хэрэгжиж байгаа үйл ажиллагааг сурталчлах, мэдээ мэдээлэл өгөх зорилгоор “Хөдөлмөр, халамж Түмэнцогт сум” нэртэй цахим хаяг нээж иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэж ажиллаж байна.

АДЗөвлөлийн хурлаар 2 удаа хуралдуулж ахмад настны асаргааны тэтгэмжид хамрагдах хүсэлтэй 1 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмжийн сунгалт 1 иргэн, Зорилтот бүлгийн хөгжүүлэх 23 өрхийг сонгон хэлэлцэж холбогдох мэргэжилтнүүдэд хүргүүлсэн.

Цэцэрлэг: Танхимын сургалтанд хамрагдах хүсэлтэй хүүхдийн судалгааг эцэг эх, асран хамгаалагчдын дунд явуулсан бөгөөд ердийн бүлэгт хамрагдвал зохих 175 хүүхдээс 149 нь буюу нийт хүүхдийн 85,1 хувь нь хамрагдах хүсэлтэй, 22 буюу 12,5 хувь нь отор нүүдлээр явж байгаа танхимын сургалтанд хамрагдах боломжгүй, үлдсэн 4 хүүхэдтэй холбогдох боломжгүй байсан. Отороор явж буй 22 хүүхдийн 13 нь цахим сургалтанд хамрагдах боломжтой бөгөөд теле хичээлээ үзэж, багш нартайгаа холбогдон даалгавар, зөвлөгөө зөвлөмжөө авч уялдаа холбоотой ажиллаж байна.

Танхимын сургалтад хамрагдах 133 хүүхдийг Эрүүл мэндийн төвтэй хамтран урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, томуу томуу төст өвчлөлтэй 7,

шүдний өвчлөлтэй 38, бусад өвчлөлтэй 5, халдварт саагийн дархлаажуулалтанд 100, цагаан хорхойн шинжилгээнд 114 хүхэд хамруулсан байна.

ЭМТөв: Эрүүл мэндийн төвийн амбулаториор 524 иргэн, алсын дуудлагаар 18, ойрын дуудлагаар 54 үйлчлэгч үйлчлүүлж, 23 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна. Товлолт дархлаажуулалтанд 100% хамруулсан. Өдрийн эмчилгээнд - , Сэргээн засахаар – 13 эмчлүүлсэн.

Эсийн шинжилгээнд-28, Артерийн гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэгт 131 иргэн харагдсан.

Энэ сард голомт бүхий бүс нутгаар зорчсон 205 иргэнийг гэрийн ажиглалтанд авч тогтмол хянаж түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулж ажиллав.

Халзан:

Уулбаян:

2021 оны 3 сарын байдлаар шинээр төрсөн-19, нас барсан- 7, шинээр гэрлэсэн- 12, цахим иргэний үнэмлэх захиалсан– 18, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 16, эцэг тогтоолгосон – 4, өөр аймгаас шилжин ирсэн -2 том хүн, 6 хүүхэд, Сүхбаатар аймгаас шилжин ирсэн – 6 том хүн, 6 хүүхэд бүртгэгдсэн байна. __

Төсөв санхүүгийн чиглэлээр:

3 сарын байдлаар орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 12398,0 мянган төгрөг орохоос 16207,6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба орлогын төлөвлөгөө 130,7 хувийн биелэлттэй байна.

Худалдан авах ажиллагааны талаар: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг хуралдан сумын засаг даргын мөрийн хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын хэтийн зорилготой уялдуулж бодлого чиглэлийг тодорхойллоо. ОНХС-ийн санал асуулгийг багийн иргэд нийтийн хурлын үеэр цаасаар болон цахимаар иргэдээс санал асуулга авлаа. Одоогоор нийт өрхийн хүн амын 50 гаруй хувийг хамруулаад байна.

Цэцэрлэгт гэр нийлүүлэх тендерт Сүхбаатар аймгийн “Хүрэл соёмбо” ХХК шалгарч 20,0 сая төгрөгөөр 5, 6 ханатай бүрэн гэр, ширээ сандал тавилгын хамт техникийн тодорхойлолтод заасны дагуу нийлүүлсэн байна.

Багийн иргэдийн нийтийн хурал болж БИНХ-ын дарга сонгох, Багийн засаг дарга сонгох хуралд оролцсон иргэдээс ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хийсэн ажлын тайлан 2021 онд хийх ажлын төлөвлөгөө, иргэдээс 2022 оны санал асуулгыг авлаа.

Байгаль орчны чиглэлээр: Хэнтий аймгийн иргэнтэй гэрээ байгуулж сумын төвийн золбин нохой устгах ажлыг хийлгэсэн ба 36 нохойг устгасан байна.

“Хоггүй цэвэрхэн-Уулбаян сум” уриан дор бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж 150 иргэн, 13 аж ахуй нэгж, албан байгууллага 23 тонн хогийг цэвэрлэлээ.

Дэлхийн ойн болон усны өдөрт зориулан цахим сургалтанд “Эко” клубийн 20 сурагчийг хамруулсан. “Усны Үнэлэмж” сэдэвт сургалтад Ерөнхий боловсролын сурагчдыг хамруулж усны зүй зохистой хэрэглээ, усны бохирдлын талаарх зөвлөмж өгч ажилласан.

Газар зохион байгуулалт: Эзэмших, ашиглах газрын эрх үүссэн 39 нэгж талбарын газрын төлбөрийн нэхэмжлэхийг үүсгэн холбогдох газруудад нь хүргэн ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: 2021 оны 3 сарын байдлаар Том малын зүй бус хорогдол 149 /толгой/ гарсан байна.

Хээлтүүлэгчийн тохироог хийж дутагдалтай хээлтүүлэгчийг дотоод нөөц боломжоороо хангахаар болов. Сумын хуьд одоо байгаа хээлтүүлэгч нь бух-132, хуц-1084, ухна-586 толгой байна. Дутагдалтай хээлтүүлэгч нь бух- 154, хуц-184, ухна-167 толгой байна 105359 хээлтэгчээс 6567 нь төллөөд байна. Үүнээс ингэ-58, гүү-77, үнээ-152, эм хонь-5024, эм ямаа- 1256 төллөөд байна. Нийт 6573 төл хүлээж авснаас төлийн бойжуулалт 100%-тай байна.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр: Сумын стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах харилцааны хэм хэмжээг тогтоох, зохицуулах аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээний талаар ярилцаж санал хүсэлтийг сонсож. “Гүн Хүсэл”, болон “Өгөөж”, Эрдэнэоргих дэлгүүрийн эрхлэгч нартай хүнсний нөөц бүрдүүлэх гэрээг хамтарч байгуулахаар болсон.

Сум хөгжүүлэх сангийн хувьд, 2021.03.22-ны байдлаар 2011-2020 оны хооронд зээл авсан 30 зээлдэгчийн 248,800,000 төгрөгийн зээл олгосон байна. Бодогдсон хүү нь 13,627,342 төгрөг. Үүнээс, зээлийн хүү, алданги ороод 115,442,314 төгрөг эргэн төлөгдсөн. Нийт үлдэгдэл 146.625.028 төгрөг байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны 02 албан даалгавар, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 1/38 албан тоот, сумын Засаг даргын 2021 оны А/27 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 4, 5-р багийн нутагт отроор ирсэн Өвөрхангай аймгийн Гучин ус сумын 5 өрх, Халзан сумын 2 өрх өөрийн сумын 10 гаруй хот айлаар орж мал эмнэлгийн ажил үйлчилгээнд хамрагдсан байдал, өвөлжөө хаваржааны ойр орчноо цэвэрлэх, хүүр сэг зэм устгах талаар үүрэг чиглэл өгч ажилласан. Мөн Улаанбаатар зам дагуу үхсэн 8 адуу, 25 үхэрийн сэг зэм хаясныг олж тогтоон сумын устгалын цэгийн нүхэнд булж устгахаар болсон.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 81051,0 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ. Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -68041,5 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 8902,7 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 4106,8 мян төг орлоо.

Сайн дурын даатгалд 156 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 8902,7 мян төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн даатгалд 120 даатгуулагчийг даатгаж 4106,7 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Эрүүл мэнд: Урьдчилан сэргийлэх үзлэг-542, амбулаторийн үзлэг –398, гэрийн дудлага-41, алсын дуудлага-41, артерийн даралт – 142, чихрийн шижингийн үзлэг-189, хөхний үзлэгт-118, эсийн шинжилгээ-4, 0-2 насны урьдчилан сэргийлэх тарилгад- 40, төрөлт-1, нас баралт-5, хавдрын нас баралт-1, цагаан хорхойн шинжилгээ-145, гэрийн ажиглалтанд 143 иргэн бүртгэгдсэнээс тандалтад 2 иргэн байна.

Ерөнхий боловсролын сургууль : Сургуулийн 437 хүүхдийн эрсдэлийн үнэлгээг АУБ нартай тулгалт хийж, эрсдэлийг тогтоов.

12 төрлийн сонгон дугуйлангийн хуваарийг гаргаж, давхардсан тоогоор 298 сурагч хамрагдаж байна.

Хүүхдийн цэцэрлэг: 3-р сарын 1-с сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа хэвийн ажиллаж эхлэсэн ба нийт хүүхдийн 92,2% танхимын сургалтанд хамрагдаж, 8,8% нь зайны сургалтаар хичээллэж байна.

Соёлын төв: Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ээждээ захидал бичээрэй” захидлын уралдааныг насанд хүрэгчид болон сурагчдын дунд зарлаж нийт 135 захидлыг хүлээн авч Насанд хүрэгчид, сурагч насны ангилалаастус бүр эхний 2 оролцогчийг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Мөн “СҮҮН ЦАЦАЛТАЙ ИЖИЙ” тоглолтыг сумын ардын авъяастнууд болон ажилчид хамтран зохион байгууллаа. Тоглолтонд нийт 15 ардын авъяастан оролцлоо. нийт 206 иргэн тоглолтанд хамрагдлаа.

Монгол цэргийн бахархал, орчин цагийн зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд “ Аавдаа хүргэх чин сэтгэлийн үг” захидлын уралдааныг насанд хүрэгчид сурагч насны ангилалаар зохион байгуулж нийт 103 иргэн хамрагдаж төрөл тус бүрээс эхний 2 байрыг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

Нийтийн номын сангаар шинээр 16 иргэн карт нээлгэж 35 ирэгсдэд 63 ном олгож үйлчиллээ .Нийтийн номын сан цахим хуудсанд ёс заншлын болон тууж, өгүүллэг 17 нийтэлж нийт 859 хүн хандалт хийсэн байна.

Хууль, эрх зүйн чиглэлээр: 2021.03.10-ны өдөр сумын удирдах ажилтны зөвлөгөөн, сургалтыг зохион байгууллаа. Төрийн албан хаагчдад мэргэжил, ур чадвар дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, хянан баталгаажуулах арга хэмжээг зохион байгуулав.

3 сарын байдлаар эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг-1, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг-1, нийт 2, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил- 8 тус тус гарсан байна.

Эрдэнэцагаан:

Удирдлага зохион байгуулалт, хууль эрх зүйн хүрээнд: erdenetsagaan.su.gov.mn сайтын мэдээллийг шинэчилж 33,4% хувийн гүйцэтгэлтэй байна .

ERP системийн талаарх сургалтад 44 албан хаагч хамрагдсан. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд 26 албан тушаал, 22 албан хаагчийг нэмсэн.

Төрийн үйлчилгээний цахим системээс 5 байгууллагын 24 лавлагаа гаргасан байна.

Сумын төсвийн болон төрийн байгууллагын 47 албан хаагчдад Ажлын уялдаа холбоог сайжруулах нь сэдэвт сургалт зөвөлгөөнийг зохион байгуулж 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнүүдийг баталгаажуулж ажилласан. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт сургалтанд 46, салбар салбарын бүгд 93 төрийн албан хаагч сургалтанд хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүллээ.

УИХ-ын гишүүд, Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой байдлын газрын дарга нарын хамтарсан бүлэг суманд ажиллаж цаг үеийн нөхцөл байдалтай танилцсан.

Мэргэжилийн ангийн 66 албан хаагч Гамшигаас хамгаалах зарлан мэдээлэх дохиогоор журмын дагуу ажиллаж бэлэн байдлаа АОБ-ын газарт мэдээгээр хүргэж ажилласан. УОК-ын 01 тоот албан даалгаврын биелэлтийн мэдээг тайлант сард АОБ-газарт 4 удаа хүргэлээ.

Төсөв санхүү: 27943321.3 төгрөгийн орлого төвлөрүүлэн орлогын төлөвлөгөө 8 % -ийн биелэлттэй байна. Үүнээс орон нутгийн 3-н төсөвт байгууллагуудад 3 сарын байдлаар 272092300 төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан.

Татвар: Малын тоо толгойн албан татварыг Адуу-1300, Үхэр-600, Хонь-500, Ямаа-1000, Мөн 1 өрхөөс 20 үхэр, 80 хонь чөлөөлөхөөр батлууллаа.

Татварын хэлтэст Хөнгөлөлт,чөлөөлөлтын тайланг 45 иргэний материалыг хянан тушаасан.

СӨБ: Аймгийн Боловсрол соёлын газраас зохион байгуулсан Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе сэдэвт онлайн сургалтад бүлгийн 31 багшийг хамруулж, бүх хүүхдийг цагаан хорхойн шинжилгээнд хамрууллаа. Шинжилгээний хариу эерэг гарсан 5 хүүхдийг 7 хоног гэрээр эмчлүүлсэн.

ЕБС: Ногоон ирээдүй эко клубын сурагчид Цагаан зээрээ хайрлан хамгаалах талаарх уншсан номынхоо сэтгэгдлийг бусдад танилцуулах уралдаанд оролцож байна.

Сурагчдын хоцрогдол арилгах агуулгыг нөхөх зорилгоор бага ангийн 1-5-р ангийн багш нар ажлын ачаалаа тэнцвэржүүлэх зорилгоор туслах түр бүлгийг байгуулан ажилласан.

5-р ангийн сурагчдаас түвшин тогтоох ахицын оношилгоо 2-ыг амжилтай зохион байгуулж анализ дүгнэлт хийж зөвлөгөөн зохион байгууллаа. Түүний мөрөөр 23,24-ны өдрүүдэд БСУГ-аас монгол хэл математикийн хичээлээр оношилгоо зохион байгуулагдаж байна. Бага боловсролын хэмжээнд сургалтын чанарт ахиц гаргах тал дээр зөвлөгөөн зохион байгуулагдсан.

Мал эмнэлэг: Малын сэг зэм устгах, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 22 –ны өдрийн А/51 дүгээр захирамжийн хүрээнд Сургууль, дотуур байрын орчмын 3000м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Соёл урлаг: Ижий бүүвэйтэй хорвоо тоглолтыг Сумын онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу билет хүргэлтээр борлууж үзвэрийг халдвар хамгаалалтын дэглэмийг сахиулан 320 хүн үзлээ. Онлайнар “Миний ээж хөөрхөн” гар зургийн уралдаан, “Ижийдээ хүргэх чин сэтгэлийн үгс” захидлын уралдаан, Ижийтэйгээ хамт цахим дууны уралдаан зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж 60 хүн оролцон тэргүүн байруулыг шагнаж урамшуулж ажилласан.

Тайлант сард номын сангаар 45 хүн үйлчлүүлж, гэрээр 27 ширхэг ном олгосон. Хөдөлгөөн-Эрүүл мэнд аяны хүрээнд Бүжгийн дугуйланд 30 сурагч хамрагдан 6 бүжгийг зааж сургаж байна.

Хүн ам зүй нийгмийн хамгаалал: “Хүүхэд хамгаалал”-ын статистик тоон үзүүлэлтийг 2020 оны байдлаар 31 үзүүлэлтээр, мөн хурдан морь унадаг 159 хүүхдүүдийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж цахимаар явуулав. 2019-2020 онд хүүхдийн тусламжын 108 утсанд ирсэн хүүхэдтэй холбоотой 2 дуудлага мэдээллийн дагуу кейс нээн хяналтанд тавьж ажиглалт хийж байгаад 2021.03.19нд хаах хүсэлт гаргаж холбогдох материалыг бүрдүүлж ГБХЗХГ-т хүргэв.

Хөдөлмөр халамж: АДЗ-ийн хурлыг сард 2 удаа хийн асаргааны сунгалт, оршуулыгн тэтгэмжүүд болон ХЭБ авагч өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийн 40 өрхийг түтгэлзүүлж, шинээр хүүхдийн мөнгөнд хамрагдах 9 хүүхдийг бүртгэсэн.

Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийг сумын иргэд, даатгуулагчдад сурталчилах ажлыг зохион байгуулах зорилгоор ЭРДЭНЭЦАГААН НИЙГМИЙН ДААТГАЛ фэйсбүүк групп нээж 200 орчим иргэдэд мэдээлэл хийсэн. СДД-д шинээр 5 даатгуулагч хамрагдсан. 2021 оны гэрээг шинэчилж 10000.0 мянган төгрөг, ЭМД-д 20 иргэний 585000 мянган төгрөгийг төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, А/О-н шимтгэл СДД, ЭМД, Архивын лавлагаа, утасны зөвөлгөө, бусад гэсэн төрлөөр нийт 624 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Байгаль хамгаалал: Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд 3 сарын 22нд “Дэлхийн усны өдрөөр” Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн сурагчдын дунд “Ус ба уур амьсгалын өөрчлөлт” хүүхдүүд бидний оролцоо сэдэвт эссе бичлэгийн уралдааныг зарлаж ЕБС-ийн 65 сурагч хамрагдсанаас эхний 3 байрыг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнав.

Сумын ахмадын холбоотой хамтарч нийтийн эзэмшлийн талбайнуудын хогийг цэвэрлэж 1тн хогийг хогийн цэгт хаяв.

Эрүүл мэнд: ЭМТ-ийн нөөц бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд тусгаарлан ажиглалтын 2 ор дэлгэхэд бэлэн болгосон ба био ноль 10ш, Ковидын түргэвчилсэн оношлуур 70, Нэг удаагийн комбинзон – 290, Нэг удаагийн халад- 282, Нэг удаагийн маск – 3000, Нэг удаагийн даавуун маск - 500, нийт 3500ш, Нэг удаагийн малгай- 210, Нэг удаагийн улавч –300, Жавелион -500, Нүүрний хаалт- 80, Цэвэр бээлий- 400, Нүдний шил- 80, Усны гутал- 8, Ахуйн бээлий -10, Спирт 76%- 5л, Белизна- 3 сав, Сода – 3 хайрцаг, Тамедин 2,5%-2, 7,5%- 5 ш тус тус нөөцлөөд байна. Тайлант сард 436 иргэнээс асуумж бөглөсөний 238-ыг тусгаарлан ажиглалтанд авч одоо хяналтад байгаа 36 иргэн байгаагаас 6 нь сумын төвд бусад нь Уул уурхайд байрлаж байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар